

Монголын Математикийн Олимпиадын цуврал
№36

МУГБ, проф. Ц. Дашдоржийн нэрэмжит
ММО-47

Улаанбаатар хот
2012он

ӨМНӨХ ҮГ

Улсын болон Олон улсын математикийн олимпиадад бэлтгэгчид, математикийн төрөлжсөн сургалттай ангийн сурагч, оюутан, багш нар, математик сонирхогч өргөн олонд зориулсан цувралын ээлжит дугаар уншигч Таны гар дээр очиж байна. Тус гарын авлагыг бэлтгэхэд ММО Зохион Байгуулах Хорооны гишүүд, МУИС-ийн математикийн ангийн оюутнууд идэвхтэй оролцлоо. Уг номын талаархи аливаа санал хүсэлтээ МУИС-ийн Алгебрийн тэнхимд ирүүлнэ үү.

Монголын Математикийн XLVII олимпиад

Редактор: Цэрэндоржийн Дашдорж

Хэвлэлийн *LATEX* эхийг бэлтгэсэн: Лхагважавын Гэрэлтуяа
2012 оны 04-р сард хэвлэв.

Гарчиг

1	ММО-47-ын дүнгийн тухай тайлан	5
2	МАТЕМАТИКИЙН АМИН ЧУХАЛ АСУУДЛУУД	
	9	
3	ММО-47-ын III даваа	25
3.1	ММО-47, VII ангийн III даваа	25
3.2	ММО-47, VIII ангийн III даваа	29
3.3	ММО-47, VIII ангийн IV даваа	33
3.4	ММО-47, IX ангийн III даваа	38
3.5	ММО-47, X ангийн III даваа	42
3.6	ММО-47, XI ангийн III даваа	45
3.7	ММО-47, Багын багшийн III даваа	53
3.8	ММО-47, Дундын багшийн III даваа	56
4	ОУ-ын математикийн 52-р олимпиад	62
5	Тусгаар тогтнолын 100 жил ба Олонлог төв сургуулийн 10 жилийн ойн нэрэмжит уралдааны чөлөөт ангилал.....	71
6	ММО-47-ын IV даваа ба ОУМО-52-ын сорил (англи хэл дээр)	
	76	

МАТЕМАТИКИЙН ОЛИМПИАДЫН СҮЛД ДУУ

Нарнаас илчийг нь авч болох уу
Сарнаас гэрлийг нь салгаж болох уу
Багш та юу гэж заасан бэ
Багын нөхөд маань санаж байна уу
Тоо тоогоо тоолон бодъёо
Томъёогоор задлан бодъёо
Олуулаа уралдан бодъёо
Олимпиадаа оролцож бодъёо

Орчлонгийн удмыг туулж болох уу
Одод эрхсийг тоолж болох уу
Эвклид юу гэж хэлсэн бэ
Эрхэм нөхөд минь санаж байна уу

Дахилт

Эрдмийн оргилд хүрч болох уу
Энгүй далайг хэмжиж болох уу
Суут эрдэмтэн Мянгат өвөөгийн
Сургаалт үгийг санаж байна уу

Дахилт

Гэрлийн хурдыг давж болох уу
Тэнгэрийн хаяанд хүрч болох уу
Дэлхийд алдартай эрдэмтэн Гауссын
Дэлгэж нээсэн онолыг саная даа

Дахилт



2000 оны Сэлэнгийн
олимпиадыг зохион
байгуулагчдын бүтээл

1 ММО-47-ын дүнгийн тухай тайлан

Ц.Дашдорж

Эрхэм хүндэт математикч багш, сурагчид аа!

ММОХорооны гишүүдээ!

ӨВ-аймгийн засаг дарга Д.Тогтохсүрэн

Эрдэм ухаанд гүн шүтлэгтэй Өвөрхангайчууд аа,

Монголын Математикийн 47-р Олимпиад 2011 оны 05 сарын 02 -07-ны хооронд Арвайхээр суманд амжилттай явагдаж дүнгээ гаргаж байна. Энэ удаагийн олимпиадад 21 аймаг, Улаанбаатар хотын нийт 22 багийн 76 бага, дундын багш, 259 сурагчид оролцож нийт 335 хүн оюун ухаан, авъяас чадвараа сорин уралдлаа.

Энэ удаагийн олимпиадыг зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангахад ӨВ аймгийн Засаг дарга, Засаг даргын тамгын газар, аймгийн Боловсрол соёлын газар, ШУТИС-ийн ӨВ-дахь салбар Технологийн сургууль болон Ерөнхий боловсрол сургууль, цэцэрлэгүүд ихээхэн хүчин чармайлт гаргаж анхаарал хандуулсныг зориуд тэмдэглэх ёстой. Дээрх нэр бүхий нийт хамт олон, сайн санаат дэмжигчиддээ Монголын нийт математикчдын өмнөөс талархал илэрхийлье.

Олимпиадад 8-р ангийн 92 сурагч оролцсоноос "Орчлон" сургуулийн сурагч Ш.Золбаяр 33 оноогоор 1-р байр эзэлж, 8-р ангийн аварга боллоо. УБ хотын 1-р сургуулийн сурагч Б.Минжин, УБ "Олонлог" сургуулийн сурагч Б.Мөнх-Эрдэнэ нар 28 оноогоор 2-р байрыг, "Олонлог" сургуулийн сурагч А.Сүхбат 27,5 оноогоор, ӨВ аймгийн Улсын тэргүүний "Мэргэд" сургуулийн сурагч Д.Мөнх-Оргил, УБ 11-р сургуулийн сурагч Д.Батзориг, Б.Ганхэт нар тус тусдаа 25 оноогоор 3-р байрыг эзэлж алт, мөнгө, хүрэл медалийн эзэд болцгоолоо.

Олимпиадад 9-р ангийн 64 сурагч оролцсоноос 1-р сургуулийн Ч.Золбоо 25 оноогоор 1-р байр эзэлж 9-р ангийн аварга су-

рагч боллоо. Увс аймгийн "Шинэ-Ирээдүй" сургуулийн сурагч Н.Төмөр-Очир УБ 1-р сургуулийн сурагч Б.Бат-Оргил нар 21 оноогоор, 2-р байрыг, "Орчлон" сургуулийн сурагч М.Ананд, 11-р сургуулийн сурагч Б.Батболд, нар 17 оноогоор, "Орчлон" сургуулийн сурагч Ш.Золбаяр 16 оноогоор тус тус 3-р байрыг эзэлж алт, мөнгө, хүрэл медалийн эзэд болцгоолоо.

Олимпиадад 10-р ангийн нийт 61 сурагч оролцсоноос "Олонлог" сургуулийн сурагч Б.Бат-Од 30 оноогоор 1-р байр эзэлж, Улсын математикийн 47-р олимпиадын 10-р ангийн аварга сурагч боллоо. 1-р сургуулийн Э.Оргил-Эрдэнэ 28 оноогоор, Б.Баатархүү 27 оноогоор 2-р байрыг, Ч.Заяа, Н.Энхтөр, Д.Галмандах нар 21 оноогоор тус тус 3-р байрыг эзэлж алт, мөнгө, хүрэл медалийн эзэд болцгоолоо.

Олимпиадад 11-р ангийн нийт 45 сурагч оролцсоноос 1-р сургуулийн Б.Батхуяг 23 оноогоор 1-р байр эзэлж Улсын математикийн 47-р олимпиадын 11-р ангийн аврага сурагч боллоо. 1-р сургуулийн Б.Төгөлдөр 22 оноогоор, Г.Халиун 18 оноогоор 2-р байрыг, 1-р сургуулийн сурагч Ц.Цэнгүүн, "Олонлог" сургуулийн сурагч О.Бямбадорж нар 17 оноогоор, Архангай аймгийн 1-р сургуулийн сурагч Д.Төвшинтөр 14 оноогоор тус тус 3-р байрыг эзэлж алт, мөнгө, хүрэл медалийн эзэд болцгоолоо.

Улсын Математикийн 47-р олимпиадад амжилттай оролцсон дээрх нэр бүхий сурагчид, олимпиадад сурагчдаа амжилттай бэлтгэж оролцуулсан багш нарт Монголын нийт математикчдын нэрийн өмнөөс чин сэтгэлийн талархал илэрхийлье. Багш нарын олимпиадыг бага, дунд гэсэн хоёр ангилалаар явуулсны дотроос бага ангийн математикийн 32 багш оролцсоноос, ӨВ аймгийн Улсын тэргүүний "Мэргэд" сургуулийн багш Д.Чулуунхүү 27 оноогоор түрүүлж, УБ "Төгсдэлгэрэх" сургуулийн багш Н.Даваа 25 оноогоор, "Орчлон" сургуулийн багш Б.Жаргалсүрэн 22,5 оноогоор удаах байруудад орлоо.

Дунд ангийн багш нарын олимпиадад нийт 44 багш оролцсоноос Сант сургуулийн багш Ч.Сугардорж 32 оноогоор түрүүлж, "Олонлог" сургуулийн багш Б.Ганбилэг 26 оноогоор II байр, Сэлэнгэ аймгийн багш Л.Буянтогтох 21 оноогоор III байрыг эзэллээ.

Багийн дүнгээр аймаг хотуудыг байр эзлүүлэхэд Н.Гэндэнсүрэн ахлагчтай Улаанбаатар баг дундаж оноо 16,4-өөр 1-р байр, П.Даарийбаамоо ахлагчтай ӨВ аймгийн баг дундаж оноо 15,2-оор 2-р байр, П.Одгэрэл ахлагчтай Увс аймгийн баг дундаж оноо 13,3-аар 3-р байранд шалгарлаа.

УБ хотын "Орчлон" сургуулийн 8-р ангийн сурагч Ш.Золбаярыг Ч.Даваадоржийн нэрэмжит "Гарамгай амжилт" тусгай шагналаар шагнах нь зүйтэй гэж ММОХороо үзлээ. ММО-47-д 1-р сургууль 12 медаль, "Олонлог" сургууль 5 медаль, "Орчлон" сургууль 4 медаль, 11-р сургууль 3 медаль, ӨВ аймаг 2 медаль, УБ-Төгсдэлгэрэх, УБ-Сант сургууль, Архангай, Увс, Сэлэнгэ аймаг тус тус 1, 1 медаль авч олимпиадад оролцогчдоо хошуучлан сайхан амжилт гаргалаа.

Энэ жилийн 7-р сард Голландын Амстарданд хотод болох ОУМО-52-ын бэлтгэлд УБ 1-р сургуулийн 11-р ангийн аврага сурагч Б.Батхуяг, Б.Төгөлдөр, Г.Халиун, Ц.Цэнгүүн, "Олонлог" сургуулийн сурагч О.Бямбадорж, Архангай аймгийн Төвшинтөр, "Олонлог" сургуулийн 10-р ангийн сурагч Б.Бат-Од, УБ 1-р сургуулийн 9-р ангийн сурагч Ч.Золбоо, "Орчлон" сургуулийн 8-р ангийн сурагч Ш.Золбаяр нарыг үлдээхээр Олимпиадын хороо шийдвэрлэлээ.

ОУМО-52-ын бэлтгэлд багтаж шалгарсан та бүхэндээ амжилт хүсч, Монголынхоо нэрийг дэлхийн тавцанд дуурсгах хүндтэй бөгөөд хариуцлагатай үйл хэргийн төлөө идэвхи чармайлт гарган сайн бэлтгэж амжилттай оролцохыг Монголын нийт Математикчдын нэрийн өмнөөс даалгаж байна.

Мэргэд сургуулийн захирал, ММОХорооны гишүүн
С.Эрдэнэбилэгийг ОУМО-2012-ийн Монголын багийн орлогч удир-
дагчаар томилох нь зүйтэй гэж ММОХороо үзлээ. Эрдэм оюун
дэлгэрч Монголд математикчдын оюун ухаан улам хөгжин дэл-
гэрэх болтугай. Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

2 МАТЕМАТИКИЙН АМИН ЧУХАЛ АСУУДЛУУД

МУИС-ийн 70 жилийн ойд зориулав

ЧӨЛӨӨТ ЛЕКЦ

1. Математик сэтгэлгээний гурван үндсэн зарчим
/2012.03.09. МУИС-ийн дугуй зааланд 16:00 цагт /
2-3. Математикт юуг, яаж судлах ёстой вэ? /Математи-
кийн бурхад юуг судалдаг вэ?/

1. Математик сэтгэлгээний (баталгааны) 3 үндсэн
зарчим
(дүрэм, теорем, томъёо)

Ц.Дашдорж

1.0. Удиртгал

Энэ удиртгал хэсэгт миний эрхэм шавь математикч П.Энхболдын 50 насны ойг тохиолдуулан явуулсан П.Энхболдын нэрэмжит Улсын Математикийн ХУралдаанд зориулж Өнөөдөр сониноос 2008.12.18 нд гаргасан нүүрт миний бичсэн 2 өгүүлэл бүрэн эхээрээ дахин хэвлэгдэж байна. Энэ өгүүлэл нь өргөн олон уншигчдад зориулсан учраас ямар ч теорем томъёогүйгээр бичигдсэн бөгөөд одоо харин түүний математикийн нарийн томъёол, теорем, томъёог 1.1- 1.3-д авч үзэж байна.

Нэрт математикч П.Энхболдын мэндэлсний 50 насны
ой, түүний нэрэмжит Математикийн Улсын Х
Уралдаанд

Математик мину

Нэгэн зүйл. Сэтгэдэг явдал бол хүмүүнийг
амьтнаас ялгах гол ялгаа болой.

Сэтгэлгээний ноён оргил бол математик гэдэгтэй усан тэнэг ч маргахгүй буйзаа. Тэгэхлээр математикаар уралдана гэдэг бол

хүмүүн гэдэг бодгалийн жинхэнэ мөн чанарын уралдаан юм. Энд би математикийн уралдаан гэдгийн дор даага, шүдлэнгийн уралдаан лугаа сурагч, оюутнуудын олимпиадуудаас эхлээд хэдэн арав, зуу бүр мянган жилийн настай математикийн хүнд бодлогуудын төлөөх математикийн бурхадын хооронд олон арван жилээр үргэлжилдэг өрсөлдөөн тэмцээнийг ч хамааруулж байгаа уншигч авгай бээр болгоох ажаамуу. Хүмүүс маш олон төрлөөр уралддаг, тэмцэлддэг. Нохой ч гэсэн уралддаг, зодолддог, зодолдохоороо бүр алахаас наахнуур юм болдог. Хэрвээ нохой зодоон гэж байдаг бол Чингисийн Монголоос минь холуур, холуур, хайран ч монгол залуус минь!!! Хүмүүн төрөлхтөн энэ сайхан нэрэндээ зохицохуйц төгс төгөлдөржсөн үедээ л оюун ухааны уралдаанд онцгой ач холбогдол өгч, түүний үр шимийг хүртэж оюуны цэнгэлийн манлайг эдлэх буй заа. Хүмүүний сэтгэлгээ хэл яриагаараа дамжин илэрдэг. Өнгөнөөс нь харвал хэл ярианы маань, үнэн чанартаа бол сэтгэлгээний маань цаад язгуур үндэс нь бичгийн хэлэндээшингэсэн байх учиртай болов уу. Язгуурын бичгээ солих нь сэтгэлгээний гажуудлаас өгсүүлээд хиймэл эрхтний олон гажгийг дагуулах бөлгөө.

Нэгэн зүйл. Дэлхий 3 зааны нуруун дээр тогтдоггүй юмаа гэхэд хүмүүний сэтгэлгээ 3 "юуны" нуруун дээр тогтдог амой.

Математик гэхээр л төгсгөлгүй олон юмны тухай яриад байна гэж бодох хандлага байж мэдэх юм. Мэдлэгийн хүрээ тэлж, гүнзгийрэх бүр авч үзэж буй юмс улам нарийн олон талтай болохын хэрээр тэдэн дээр хийгдэж үйлдлүүд ч мөн тэр чинээгээр даган өөрчлөгдөж, тэндэх зүй тогтлууд нарийн түвэгтэй харагдана уу гэхээс биш дээр хэлсэн 3 үндсэн зарчмаас өөр илүү шинэ сэтгэлгээний зарчим гарч ирнэ гэж даанч байдаггүй болой. Одоо би энэ зарчмуудаа ойлгомжтойгоор тайлбарлая. Монголын математикийн олимпиадын хороо сэдвээ урьдчилан зарлаж байгаад багш, сурагчдын дунд Математикийн төрөлжсөн цуврал олимпиад гэгчийг явуулдаг. Тухайлбал Дирихлейн зарчим гэсэн сэдэв байна.

I ангийн баатрууд ч, V ангийн бацаанууд ч, X ангийн ах, эгч нарч, олон улсын Математикийн олимпиадын хамаг ме-

далийг хамсан МУИС-ийн онолын математикийн ангийн данагар оюутнууд ч, тэдний багш нарч ялгаагүй бүгд адилхан ганцхан энэ сэдвээр л гурав, гурван бодлого бодож уралддаг. Сонин байгаа биз. Тоо бодох гэж улайраад ертөнцийн бүх юмыг мартчихсан бацааныг харна гэдэг математикч хүний бас нэг жаргал даа. Дирихлейн зарчмын энгийн хэлбэр нь 5 туулайг 4 торонд яаж ч байрлуулсан аль аль нэг торонд дор хаяж 2 туулай заавал бий гэсэн хэлбэрээр томьёологддог. Математикийн аль ч түвшний сэтгэлгээнд ямар дугаартай хэдэн торыг яаж сонгох вэ, ямар дугаартай хэдэн туулайг яаж сонгох вэ, хамийн гол асуудал бол тухайн авч үзэж буй бодлоготой холбоотойгоор туулайнуудаа торонд яаж байрлуулах вэ гэдэг л жинхэнэ бодох ёстой асуудал болохоос биш дүгнэлтийг нь Дирихлейн зарчим аяндаа хийгээд өгнө. Нөгөө нэг зарчим бол оруулах, гаргах зарчим юм. Манай ангид шатар тоглодог төд, теннис тоглодог төдөн хүүхэд бий г.м. нөхцөлд энэ гурвууланг нь тоглодог хэдэн хүүхэд бий вэ? г.м. асуудалд хариулт өгөх томьёонууд дээр ажиллах явдал юм. Гурав дахь зарчим бол Холлын ялгаатай төлөөлөгчдийг сонгох зарчим буюу саяын бодлогын томьёололд ямар нөхцөл биелж байвал шатар тоглодог 1, даам тоглодог 1, теннис тоглодог 1 хүүхдийг сонгож авч чадах вэ гэсэн зарчим юм. Сэтгэлгээний тулгуур зарчмуудыг үе шаттай ингэж хялбарчлан бол өгвөл эхийн сүүтэй нь хамт балчир оюунд нь гүн суулгаж өгөхгүй бол ямарч авьяас байгаад их математикт амжилт олох магадлал бага юм. Дүрмийг нь хэлээд өгвөл Рубикийн шоог академич, цэцэрлэгийн сэргэлэн бацаан хоёрын хэн нь хурдан эвлүүлэх бол. Монголийн Математикийн олимпиадын хороо математикт ингэж ханддаг болсноор манай математикийн суурь боловсролын түвшин дэлхийн дунджаас дээгүүр байгаа, харин олимпиадын түлшин дэлхийд тэргүүлж байгаа гэж хэлэхээсээ би огт айхгүй байна. Олимпиадад амжилт гаргахын тулд олон бодлого бодож их цаг гаргахаас аль болохоор сэрэмжилж, оновчтой цөөн бодлогоор оюун ухааныг нь хөгжүүлэх тал дээр онц анхаарч ажиллах нь манай математикийн багш нарын эрхэм үүрэг болой. Хэрвээ ивээн тэтгэгчид олддогсон бол ганцхан Дирихлейн зарчмаар л гэхэд улирал бүр

уралдаан явуулаад байхад наанадаж Дирихлейн зарчим цаашилбал математик маань улам баялаг, улам хүчтэй, улам гүн, улам агуу баян болж харагдахын сацуу, математикийг мэдрэх хувьтай төрсөн хэн бүхэнд оюуны цэнгэлийн дээдийг эдлүүлж мянга, мянган охид хөвгүүдийг математикийн гайхамшигт ертөнц рүү даллан дуудах буйзаа.

Одоо би дээрх 3 зарчмын агуу гэдгийг мандуулах үүднээс бяцхан уянгын халил хийе. Хэрвээ бүх математикийг өөртөө багтаасан ганцхан томьёо байдагсан бол түүний баталгаанд дээрх 3 зарчим тус бүр гурвантаа ашиглагдах буй заа.

Нэгэн зүйл. Математикийн гоо сайхан бол ертөнцийн бүх гоо сайхны оргилын оргил мөн.

Ертөнцийг гоо сайхан л аварна гэж би хэлээгүй ээ, нэг номтой хүн айлдсан гэдэг байх. Бас "Математик бол шинжлэх ухааны хаан, математикийн хатан хаан нь арифметик" гэж математикийн хаан Гаусс гуай хэлсэн гэдэг. Хүмүүний мэдрэхүйнүүдийн дээд хэлбэр нь сэтгэж мэдрэхүй болой. Эндээс математикийн гоо сайхан бол ертөнцийн бүх гоо сайхны оргилын оргил мөнөөс мөн гэж төвөггүйхэн мөрдөгдөх байхаа. Математикийн гоо сайхныг харж, сонсож, үнэрлэж мэдрэх боломжгүй, зөвхөн сэтгэж л мэдрэх боломжтой юм. Төрөлхийн дүлий хүмүүн хүмүүсийн ярилцахыг хараад юм идээгүй байж амаа хөдөлгөөд байдаг тэнэг лүднүүд юмдаа гэж бодох лугаа тун адил санаа сэтгэх мэдрэмж нь тэг эрхэмд төрөхийг байг гэж аргагүй ээ. Сайхан, муухай математикийг ялгаж чадахгүй, өөрөөр хэлбэл математик урлагийн хэмжээнд ойлгогдохгүй л байвал эрхэм та онолын математикт олигтой амжилт олохгүй л болов уу.

Үнэнхүү хүчтэй теорем мөн л юм бол өгүүлшгүй гоо сайхныг агуулна гэсэн аксиом байна гээд айлдчихвал үнэнээс зөрөхгүй гэдэгт миний бие харин ч нэг итгэлтэй байна. Гоо сайхан ертөнцийг аварна гэдэг дэмий үг биш юм бол математикийн гоо сайхан Чингисийн Монголчуудын минь хийморийг сэргээж, онгодыг дуудах шидтэй байгаасай, хурай, хурай!

Нэгэн зүйл. Муухай математикт ертөнцөд байр байхгүй гэж би хэлээгүй ээ, Английн алдарт математикч

Харди айлдсаан.

Энэ бол аргаа барсан математикч хүний үг болохоос биш, муухай математик байдаггүй гэсэн үг хараахан биш болой.

Энэ үгийг миний шавь П.Энхболд хэлэх их дуртай байсан. Жаахан урт заваан баталгааг хараад л шавь маань муухай математикт ертөнцөд байр байхгүй гэж орос юмуу англиар хэлээд тэр дор нь маш товч ганган баталгаа хийчихдэгсэн. Нөгөө гоё баталгаанаасаа болоод нөгөө бодлого маань ой ухааныг нь цэнгүүлж, сэнгэнэсэн нэг аяга айраг хүртчихсэн юм шиг сэргээх явдал олонтаа тохиолдож нэг хэсэгтээ л ярианы сэдэв болдогсон. Бодлогыг зөвхөн бодохын тулд биш сэтгэлийн таашаал авахын тулд ингэж бодох хэрэгтэй юм байна гэдгийг шавиасаа анх ойлгосон болохоор П.Энхболддоо би их хайртай байдаг юм.

Бүр 70-аад онд Зөвлөлтийн хэдэн нэртэй алгебрч Монголын алгебрчдыг "Днестровский тетрадь" -аас өөр сэдвээр ажиллахгүй байхыг зөвлөөд, хэрэв өөр сэдвээр ажиллавал ажлаа манай руу битгий явуулаарай гэж захиж хэлснийг миний бие давтан хэлэх дуртай байдаг юм.

Энэ бол математикийн шинжлэх ухааныхаа үүднээс бол огт хэрэггүй гэж хэлж болохоор сэдвийг сонгож авч бие биендээ харилцан асуудал дэвшүүлж түүндээ хариулсан болж толгой эргэм олон теорем, өгүүллүүд бичээд математикийн шинжлэх ухаан, эрдмийн зэрэг цол, төрийн мөнгөөр тоглож байдаг улс гүрэн дамнасан бүлэглэлүүдэд орчих вий гэснээс сэрэмжилж хэлсэн захиас болохыг л тэр үед нь ойлгож билээ. Чухам энэ л утгаар муухай математик гэж хэлсэн болов уу гэж би хувьдаа таамагладаг юм. Байдлыг ажаад дуугүй байгаад байвал муухай математик Монголд маань нилээд амь бөхтэй суурьших нь бололтой. Математик болоод математик сэтгэлгээний наад захын мэдлэггүйгээ ойлгох тэнхэлгүйгээс би хэдэн зуун теорем баталсан гэж хөөрцөглөдөг математикийн шинжлэх ухааны докторууд олшрох янзтай. Ээ базарвааний хумпад, муухай математик Чингисийн Монголоос минь холуур, холуур.

Нэгэн зүйл. Цаг хоживол бүхнийг хожино.

Ямар ч мэргэжлийн хүн цаг хожихын тулд математикийг

жаахан суралтай гээд хэлчихвэл яадаг бол. Энд би математик гэдгийн дор математикийн томьёонуудыг тогтоо, теоремуудыг цээжил гэж огт хэлээгүй, зөвхөн математикийн хувиргалтуудыг чөлөөтэй хийх арга техникийг эзэмшин математик сэтгэлгээний наад захын төртэй бол гэж л хэлэх гэсэн юм. Шинжлэх ухааны дийлэнх салбаруудыг математикийн хэлэнд хөрвүүлчихсэн орчуулга аль хэдийнэ бэлэн байгаа. Үүнээс цааш бол гол нь математикчийн л ажил үлдэнэ, өөрөөр хэлбэл тухайн салбарын цөөн дүрмийг илэрхийлж буй томьёонууд дээр л математик хувиргалт чөлөөтэй хийж хүссэн үр дүнгээ, хүссэн цагтаа хэнээр ч заалгалгүй гаргаж авах явдал болой. Түүнээс биш тухайн салбарын бүх үр дүнгүүдийг тогтооно гэвэл ямар ч жижиг салбар байгаад, ямар ч том толгой байгаад нэмэргүй хүмүүний тархины багтаамжийн бодит боломжийг хэт давсан мэдээлэл байгаа шүүдээ.

Цаг хугацаа бол бүхний багш, цагийг хожвол бүхнийг хожно.

**Ардын багшийн ганц бодлогоор өгөх эрдмийг
Арчаагүй багш зуун бодлогоор залхаах болой**

Монголын математикийн хурц од байсан юм

П.Энхболд маань 1975 онд IX ангид байхдаа Улсын Математикийн олимпиадын эцсийн хоёр даваанд X ангийнхантай өрсөлдөн хол тасархай түрүүлж билээ. Тэр жилээ Олон улсын Математикийн олимпиадаас хүрэл медаль авчрав. Тэр үед бидний бэлтгэх хэмжээ ч хүрэл медиалаас дээш гарахааргүй байсан гэдэгтэй санал нийлнэ. Одоо бол харин элбэг алтан медаль авахуйц хэмжээнд бэлтгэдэг болсон. П.Энхболд IX анги төгсөөд тэр намраа шууд МУИС-ийн тооны ангид элсэв. Дахиж ийм хүүхэдтэй таараач уу, үгүйчүү, тэгээд ч чиний их сургуульд байх хугацаа дуусгавар болж байгаа шүү гэж их сургуулийн удирдлагаас надад үргэлж сануулж байдгийг бодолцоод амжиж ганц хэрэгтэй хүн бэлтгэх нь зүйтэй гэж сэтгээд есөн сарын 1-ээс П.Энхболдыгоо шууд л математикийн V ангийн алгебрийн тусгай курс ба математикийн III курсын математик логикийн хичээл-

дээ суулгав. Бараг л П.Энхболддоо зориулж V курсынхэнд Га-
луагийн онол, III курсынхэнд Алгоритм ба рекурсив функций
онол хичээлүүдийг МУИС-ийн түүхэнд шинээр зааж эхлэв. Эх-
ний хэдэн сар тэвдэж л байх шиг байснаа, хагас жилээс хойш уг
хичээлүүдийг гүйцэд ойлгодог нь П.Энхболд маань болж ах, эгч
нартаа бодлого бодож өгч, миний өмнөөс давтлага ч хийлгэдэг
болов.

Тоог алгебрийн ба трансцендент гэж хоёр ангид ху-
ваадгийг өнгөрсөн зуунд тогтоосон. Төгслөг тооны радикал ба
арифметикийн дөрвөн үйлдлээр бичигдэх тоо бүр алгебрийн тоо
болдог номтой. Тэгвэл үүний урвуу нь хүчинтэй юу гэсэн зүй
ёсны асуудлыг П.Энхболддоо тавилаа.

П.Энхболд маань тэр хавраа:

Теорем (П.Энхболд, 1976). $t, l = 2t - 1, q = ml + 1, p$ анхны
тоонууд ба $t \geq 3, p \neq q$ байг. $q - 1 \nmid m \cdot \text{ind} p$ бол

$$\sqrt[t+1]{qp + p \sqrt[t+1]{qp + p \sqrt[t+1]{qp + \dots}}} \quad (*)$$

илэрхийлэл радикалаар илэрхийлэгдэхгүй алгебрийн тоо байна.
 $p \in \mathbb{Z}_q^* = \langle \varrho \rangle_{q-1} \Rightarrow p = \varrho^s, 1 \leq s \leq q - 1$ байх $s \in N$ -г $\text{ind} p$
гэж тэмдэглэсэн.

Теорем (П.Энхболд, 1976). $t, l = 2t - 1$ анхны тоонууд ба
 $t \geq 3$ бол (*) нь теорем 1-ийн нөхцөлд оршихоор p, q анхны тооны
төгсгөлгүй олон хос олдоно гэсэн гайхамшигт теоремуудыг ба-
талж дээрх асуудалд сөрөг хариу өгөв.

Ийнхүү анхны тийм тоог математикчид гараараа барьж
нүдээрээ харав. Баталгаа нь ганган бөгөөд өндөр техник ур-
лагтай нь сайхан байлаа. Улсын оюутны эрдэм шинжилгээний
уралдаанд тэргүүн байр эзлэв. Үүнийг урьд нь хэн ч хийгээгүй
гэдгийг би сайн мэдэж байснаас гадна энэ бол зүй ёсны асуу-
дал гэдэг нь хэнд ч ойлгомжтой тул бушуухан дэлхийн матема-
тикчдын сонорт хүргэхсэн гэж яарлаа. Ашгүй тэр намар Олон
улсын оюутны эрдэм шинжилгээний ажлын уралдаан Унгарт бо-
лох байлаа. Мэдээж тэргүүн байрыг авсан багш, шавь хоёр явж л
таараа. МУИС-ийн эрдэм шинжилгээ хариуцсан нөхдүүд ч явах

бэлтгэлээ хангахыг үүрэг болгов.

Тавих илтгэлээ орос, англи хэл дээр бичиж жин тан болгов. Гэтэл бид хоёрыг л хасаад бусад нь явцгаав. Шавьд маань хэлсэн үг нь "Чиний эрдэм шинжилгээний ажлын удирдагч чинь Дашдорж байгаа цагт чи амжилт олохгүй шүү, хурдхан удирдагчаа солих хэрэгтэй. Нөхөр Дашдорж математикийн III, V курсынхэнд дур мэдэн сургалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй юм заасан сураг байгаа. Тэр нөхрийн их сургуульд дураараа дургидаг явдалд одоо цэг тавих цаг болсон байлгүй" гэж хэлсэн байв. Би ч үүнийг бас гадарлаж л байсан юм.

Үүний өмнөхөн Польшид Коперникийн 500 жилийн ойн нэрэмжит нэг жилийн өндөр хангамжтай мэргэжил дээшлүүлэх сургалтад явахаас зөвхөн намайг хасч уг боломжийг алдсанаа МУИС-ийн нийт багш нарын хурал дээр их л ид хав болгон тайлбарлаж байсан юм. МУИС-ийн удирдлага цаг үргэлж л хөөнө, зайлуулна гэж намайг сүрдүүлдэг ч Ү.Санжмятав, А.Мекей багш нар маань "явуулахад ч татгалзах юм алга ганцхан хичээлийг нь заах хүн алга байна" гэж аргацаагаад байдаг байв. Ингээд шавийгаа А.Мекей багш дээр хичээллүүлэхээр болов. Бид хоёрт дээрх ажлаа үргэлжлүүлэх өөр шинэ хэлбэрийн алгебрийн тоо олох, дараа нь бүр ерөнхий теорем батлах гээд дэндүү их ажил байсан юм сан. Үүнийгээ аспирантурын дараа л нэг сайхан цаг ирвэл дахин авч үзье гэж тохиров. Гэвч тийм цаг ирэх учиргүй байжээ. Шавь маань Москвагийн их сургуулийн аспирантурт дөнгөж очоод байхдаа есөн давхраас унаж нас барав. Энэ үйл явдал ч их учир битүүлэг юм. Ямар сайндаа л зөвлөлтийн цагдаа нар газар дээр нь ирж үзээд энэ хүнийг амьсгал хураасны нь дараа шидсэн байна гэж оношлоод хэсэг хүнийг байцааж хэдэн сар болсны дараа гэнэт тэр хүн өөрөө унажээ гэсэн хариу ирүүлж байхавдээ.

Ингэж Монголын математикийн хамгийн хурц од цаг үеийн золиос болж билээ. Галуа ч гэсэн дунд сургуулийн сурагч байхдаа энэ гайхамшигт онолоо нээсэн ч түүний ажлыг тэр үед дэлхий ойлгохоос дэндүү хол байсандаа. Математикт хамгийн олон теорем баталсан гэж түүхэнд тэмдэглэгдсэн Францын ШУА-ийн

ерөнхийлөгч Коши түүний ажлыг ойлгох боломжгүй байснаас Галуа 21 насандаа дуэлиэр нас барсан юм. Хэрвээ Галуагийн онол байхгүй байсан бол одоогийн математик ямар өрөвдмөөр ядмаг царайтай байх бол гэхээс айдас төрдөг юм.

Миний бие залуудаа ингэж будилж мунгинаж явахдаа Монголын болоод ертөнцийн хамгийн гайхамшигт хоёр хүмүүнтэй тун дотно харьцаатай байж, бие биеэ хайрлаж хамгаалж, түүнийхээ золиос болох шахаж явлаадаа.

Энэ цагийн (үнэндээ бол бүх л үеийн) хамгийн гайхамшигт алгебрч Е.И.Зельманов 1979 онд "энэ хүний ажил заавал зөв байх ёстой гэж" намайг өмгөөлөн Зөвлөлтийн алгебрчдыг эсэргүүцсэнийхээ төлөө кандидатынхаа хамгаалалт дээр "унаж" байсан юм шүү. Тухайн цаг үе үнэнийг заримдаа дийлдэг боловч түүхийн өмнө л тар нь танигддаг юм хойно доо.

П.Энхболд маань өдөрт манайд хэд орж ирнэ. Хэрэв ирэхгүй бол эхнэр маань намайг загнана, чи хүүхэд загначихав уу гэж. Яг л манай хоёр банди шиг манайд эрх дураараа байна. Ямар сайндаа л эхнэр маань "чамайг ингэж дураараа загнаж яваад амьтанд хорлогдчихвол Энхболд л энэ хоёр хүүтэй чинь үүрч аваачиж хаях байх шүү. Их сургууль ч ганц ачааны тэрэг өгөхгүй биз" хэлж байхавдээ.

Е.Зельманов, П.Энхболд нартай холбоотой эрхэм дээд хүний хамгийн эрхэм дээд мөс чанарын олон сайхан дурсамж надад байдаг. Сайн хүн нэг үгтэй, сайн морь нэг явдалтай гэж П.Энхболдын маань 18 настайдаа үнэндээ бол 17 нас дөрвөн сартайдаа баталсан дээрх хоёр теорем түүхэнд мөнхрөх нь гарцаагүй.

1.1. Оруулах ба гаргах зарчим

$A_i \subseteq V$, $i = \overline{1, n}$, $|A_i| < \infty$, $A = \bigcup A_i$ бол

$$|A| = \left| \bigcup A_i \right| = \sum_{i=1}^n |A_i| - \sum_{1 \leq i < j \leq n} |A_i \cap A_j| + \dots + (-1)^{n+1} |A_1 \cap \dots \cap A_n| \quad (1)$$

$$|\overline{A_1} \cap \dots \cap \overline{A_n}| = |\overline{A_1 \cup \dots \cup A_n}| = \left| V \setminus \bigcup_{i=1}^n A_i \right| = |V| - \left| \bigcup_{i=1}^n A_i \right| \quad (2)$$

(1) ба (2)-д $\cap \leftrightarrow \cup$ гэж сольж болно (МК-I, 5.2). Бодлого бодох үед $A \cup B$ ба $A \cap B$ -г $A + B$ ба AB гэж бичвэл хялбар байдаг. А олонлогийн хэмжээс $|A|$ -г бодохын тулд A_i -үүдийг яаж сонгож авах вэ? түүний хэмжээс $|A_i|$ -г яаж бодох вэ гэдэг нь тухайн салбар бүрт өөрийн дүрмээр хийгдэнэ.

Бодлого 1. 12 ялгаатай номыг өнгө тус бүрээс ядаж 2 ном хавтаслагдсан байхаар 3 өнгөөр хавтаслах боломжийн тоог ол (МК-I 5.4.8).

Бодолт. $V = \{x = x_1 \dots x_{12} \mid x_i \text{ нь } i - \text{р номын хавтасны өнгө}\}$,
 $|V| = 3^{12}$

$A = \{x \in V \mid x \text{ нь бодлогын нөхцлийг хангана}\} \subseteq V$, $|A| = ?$

$A_i = \{x \in V \mid i - \text{р өнгөөр 2-оос цөөн ном хавтаслагдсан}\} \subseteq V$ гэвэл түүний гүйцээлт

$\overline{A_i} = \{x \in V \mid i - \text{р өнгөөр ядаж 2 ном хавтаслагдсан}\} \subseteq V$ ба $A = \cap \overline{A_i}$ болох тул Морганы дүрэм (МК-I, 4.2.3)-ээр

$$A = \cap \overline{A_i} = \overline{\cup A_i}; \quad |\cup A_i| \stackrel{(1)}{=} \sum |A_i| - \sum |A_i A_j| + |A_1 A_2 A_3|$$

$A_1 = A_{10} + A_{11}$, энд

$A_{1i} = \{x \in A_1 \mid i - \text{р өнгөөр яг } i \text{ ном хавтаслагдсан}\}$, $A_{10} \cap A_{11} = \emptyset$ болох тул $|A_1| = |A_{10}| + |A_{11}| = 2^{12} + C_{12}^1 \cdot 2^{11}$,

$$\begin{aligned} |A_1 A_2| &= |(A_{10} + A_{11})(A_{20} + A_{21})| \\ &= |A_{10} A_{20} + A_{11} A_{20} + A_{10} A_{21} + A_{11} A_{21}| \\ &= 1^{12} + 2C_{12}^1 1^{11} + C_{12}^2 2! \cdot 1^{10} \end{aligned}$$

болно, учир нь $A_{10} A_{20}, \dots, A_{11} A_{21}$ -үүд хос хосоороо үл огтлолцно.

Мөн $A_1 A_2 A_3 = \emptyset$ байх нь илэрхий тул

$|\cup A_i| = 3(2^{12} + 12 \cdot 2^{11}) - C_3^2 \cdot (1^{12} + 2 \cdot 12 \cdot 1^{11} + C_{12}^2 \cdot 2! \cdot 1^{10})$ ба
 $\forall X \subseteq V$ -ийн хувьд $|\overline{X}| = |V| - |X|$ тул $|A| = |\overline{\cup A_i}| = 3^{12} - |\cup A_i|$

Бодлого 2. Адил үсэг зэрэгцэж ороогүй байхаар "Дашдондог" гэдэг үгэнд үсгүүдийн байрыг хичнээн янзаар сольж болох вэ (МК-I, 5.7.8) ?

(1)-(2) томъёогоор бодогдохгүй хэмжээс гэж ертөнцөд байдаггүй болой.

$1 \leq k \leq n$ байх k -г бэхлэе. $1 \leq i_1 < i_2 < \dots < i_k \leq n$,

$$S_{i_1 \dots i_k} = \left| \bigcap_{j=1}^k A_{i_j} \right|, \quad M_k = \sum S_{i_1 \dots i_k}, \quad S = \left| \bigcup_1^n A_i \right| \quad \text{байг.}$$

$$\text{Тэгвэл } S = M_1 - M_2 + M_3 - \dots + (-1)^{n+1} M_n \quad (1')$$

гэж (1)-ийг бичиж болно.

$$\text{m тэгш бол } S \geq M_1 - M_2 + M_3 - \dots + (-1)^{m+1} M_m \quad (3)$$

$$\text{m сондгой бол } S \leq M_1 - M_2 + M_3 - \dots + (-1)^{m+1} M_m \quad (4)$$

(3) ба (4)-ын баталгааг МК-I, 5.9.15-аас харж болно.

Бодлого 3. 6 талбайтай квадратад тус бүр нь 3 талбайтай 3 олон өнцөгт байрлажээ. Тэгвэл эднээс ерөнхий хэсгийн (огтлолцлын) талбай нь 1-ээс багагүй байх хоёр олон өнцөгт олдохыг үзүүл (МК-I, 5.9.22a).

Бодолт. A_i нь i -р олон өнцөгт, $S_i = |A_i|$, $S = |\cup A_i|$ гэвэл

$$6 = M \geq S \stackrel{(1')}{=} M_1 - M_2 + M_3 = \sum S_i - \sum S_{ij} + S_{123}$$

$$\rightarrow S_{12} + S_{13} + S_{23} = \sum S_{ij} \geq 9 - 6 + S_{123} = 3 + S_{123} \geq 3 \rightarrow \exists S_{ij} \geq 1.$$

Бодлого 4 (Нөхөөсний тухай Дынкины бодлого). 1 талбайтай тэрлэгэн дээр тус бүрийн талбай нь 0,5-аас багагүй 5 нөхөөс тавьжээ. Ерөнхий хэсгийн талбай нь 0,2 -оос багагүй байх 2 нөхөөс олдохыг үзүүл (МК-I, 5.9.23).

↑ A_i бол i -р нөхөөс, $S = |A_i|$, $S = |\cup A_i|$ ба M тэрлэгний талбай гэвэл

$$M \geq S \stackrel{(1')}{=} M_1 - M_2 + M_3 - M_4 + M_5 \quad \text{буюу}$$

$$M - M_1 + M_2 - M_3 + M_4 - M_5 \geq 0 \quad (5)$$

гэж гарна. Үүнтэй төстэй тэнцэл бишүүдийг одоо нөхөөс тус бүрийн хувьд бичье: A_1 нөхөөс нь $A_1A_2, A_1A_3, A_1A_4, A_1A_5$ нөхөөсүүд бүхий тэрлэгний хэсэг тул (5)-г S_1 -ийн хувьд бичвэл: $S_1 - \sum S_{1i} + \sum S_{1ij} - \sum S_{1ijk} + S_{12345} \geq 0$ болно. Бүх 5 нөхөөсний хувьд гарах ийм тэнцэл бишүүдийг нэмбэл ($S_{12} = |A_1A_2| = S_{21}$ г.м.):

$$M_1 - 2M_2 + 3M_3 - 4M_4 + 5M_5 \geq 0 \quad (6)$$

болно, учир нь $S_{i_1 \dots i_k}$ нэмэгдэхүүн нь $i_1, \dots, i_k$ нөхөөсүүдийн хувьд бичигдсэн тэнцэл биш бүрт орох тул нийлбэрт k коэффициенттэй орно.

$$3(5) - (6) : 3M - 2M_1 + M_2 - M_4 + 2M_5 \geq 0 \quad (7)$$

Үүндээр $M_4 - 2M_5 \geq 0$ (S_{12345} нь $S_{i_1i_2i_3i_4}$ бүрд орох тул $M_4 \geq 5M_5 \geq 2M_5$) -ийг нэмбэл

$$3M - 2M_1 + M_2 \geq 0 \text{ буюу } M_2 \geq 2M_1 - 3M \geq 5 - 3 = 2$$

5 нөхөөснөөс $C_5^2 = 10$ хосыг үүсгэж болох тул энэ хосуудын аль нэгний нь огтлолцлын талбай $M_2/10 \geq 2/10 = 0.2$ -оос багагүй байна. $\downarrow$

1.2. Ялгаатай төлөөлөгчдийн систем(ятс).

$S_1, \dots, S_m \subseteq S, a_i \in S_i, i \neq j$ үед $a_i \neq a_j$ бол $a_1, \dots, a_m$ -ийг $S_1, \dots, S_m$ -ийн ЯТС гэдэг.

Теорем 1(Ф. Холл, 1935).

$S_1, \dots, S_m \subseteq S$ -ийн хувьд ЯТС оршино $\Leftrightarrow \forall k$ ба $\forall i_j$ -ийн хувьд $|S_{i_1} \cup \dots \cup S_{i_k}| \geq k$

Бодлого 1. $S = \bigcup_{i=1}^m A_i = \bigcup_{i=1}^m B_i, |A_i| = |B_j|, i \neq j$ үед $A_i \cap A_j = B_i \cap B_j = \emptyset$ бол $A_1, \dots, A_m$ ба $B_1, \dots, B_m$ -ийн хувьд ерөнхий $\exists$ ЯТС.

$\uparrow S_i = \{A_j | A_j \cap B_i \neq \emptyset\}, \overline{i} = 1, m. \{i_1, \dots, i_k\} \subseteq \{1, \dots, m\} = [m]$ байг. Хэрэв $|S_{i_1} \cup \dots \cup S_{i_k}| < k$ бол $B_{i_1}, \dots, B_{i_k}$ -үүд нь $A_1, \dots, A_m$ -ийн k -аас цөөн олонлогийн нэгдэлд орно. Энэ нь $|B_{i_1} \cup \dots \cup B_{i_k}| = k|B_i| \leq (k-1)|A_i| = (k-1)|B_i|$ буюу $k \leq k-1$ болж зөрчилд хүргэнэ.

Иймд $|S_{i_1} \cup \dots \cup S_{i_k}| \geq k \rightarrow$ Холлын теоремоор $S_1, \dots, S_m$ -ийн хувьд $A_{i_1}, \dots, A_{i_m}$ гэсэн ЯТС олдоно. S_i -ийн тодорхойлолтоос

$A_{i_k} \cap B_k \neq \emptyset, \quad k = \overline{1, m}. \quad x_k \in A_{i_k} \cap B_k, \quad k = \overline{1, m}$ байг. Тэгвэл $x_1, \dots, x_m$ нь $A_{i_1}, \dots, A_{i_m}$ ба $B_1, \dots, B_m$ -ийн ерөнхий ЯТС боллоо.

1.3.Рамсейн теорем

$|S| = n$ байх S олонлогийн элементүүдийг 2 хайрцагт хийхэд I хайрцагт q_1 , эсвэл II хайрцагт q_2 элемент байхын тулд $n = ?$

$n \geq q_1 + q_2 - 1 = N(q_1, q_2; 1)$ байх нь илэрхий. Хэрэв t хайрцаг байна гээд ямар нэг i дүгээр хайрцагт q_1 элемент байх тухай яривал

$$N(q_1, q_2, \dots, q_t; 1) = \sum_1^t q_i - (t - 1) \quad (1)$$

болно. Энэ бол Дирихлейн зарчим юм. Сая S -ийн элементүүдийг нэг нэгээр буюу түүний нэг элементтэй дэд олонлогуудыг хийх тухай ярилаа.

S -ийн r элементтэй дэд олонлогууд (r -дэд олонлогууд)-ыг хайрцагуудад хийх асуудлыг авч үзээд Английн логикч, эдийн засагч Рамсей 1929 онд дараах теорем батлав. $|S_n| = n$ ба $P_r(S_n) = \{X \subseteq S_n \mid |X| = r\}$ байг.

Теорем 1(Рамсей, 1929). $r \geq 1, q_i \geq r, i = \overline{1, t}$ байг.

$\exists N = N(q_1, \dots, q_t; r)$ хамгийн бага натурал тоо, $\forall n \in \mathbb{N}$ ба дурын эрэмбэлэгдсэн t -хуваалт (эсвэл t ялгаатай хайрцагт байрлуулах)

$P_r(S_n) = A_1 \cup \dots \cup A_t$ -ийн хувьд $\exists i, \exists X \subseteq S_n, |X| = q_i,$

$P_r(X) \subseteq A_i.$

↑ (1) байгаа тул r -ээр индукцлэх нь ойлгомжтой.

$$N(q_1, q_2; r)$$

Индукцэд үзэж буйгаар $p_1 = N(q_1 - 1, q_2; r),$

$p_2 = N(q_1, q_2 - 1; r), N(p_1, p_2; r - 1)$ тоонууд оршин байгаа.

$N(q_1, q_2; r) \leq N(p_1, p_2; r - 1) + 1$ гэж баталдаг. Тухайн бодлоготой холбоотойгоор r, q_i, t -үүд нь ямар тоо байгаад A_i дэд олонлогуудыг яаж сонгож авахаасл математикчийн ур чадвар хамаарна, бусдыг нь Рамсейн теорем аяндаа хийгээд өгнө. За одоо бодлого руугаа орцгооё.

Бодлого 1(ОУМО-6, 1964 он). 17 эрдэмтэн 3 төрлийн сэдвээр харилцан захидал солилцжээ. Тэгвэл 1 төрлийн сэдвээр харилцсан 3 эрдэмтэн бий гэдгийг батал.

↑ x, y хоёр k -р сэдвээр харилцсан $\Leftrightarrow xy$ интервал k өнгө ($\theta(xy) = k$)—тэй гээ. x -аас $16 = \underline{3} \cdot 5 + 1$ интервал гарах тул нэг өнгийн ($k = 1$ өнгийн) 6 интервал $\theta(xy_1) = \dots = \theta(xy_6) = k = 1$ олдоно. Хэрэв $\theta(y_i y_j) = 1$ бол $\Delta xy_i y_j$ нь 1 өнгөтэй болно. Иймд $\forall i, j \theta(y_i y_j) = 2 \vee 3$ гээ. $y_1, \dots, y_6$ г авч үзэхэд y -ээс $5 = \underline{2} \cdot 2 + 1$ интервал гарах тул нэг өнгийн(2 өнгөтэй) 3 интервал олдоно,

$$\text{ө.х. } \theta(y_1 y_2) = \theta(y_1 y_3) = \theta(y_1 y_4) = 2$$

Хэрэв $\exists y_i y_j, 2 \leq i, j \leq 4, \theta(y_i y_j) = 2$ бол $\Delta y_1 y_i y_j$ нь 2 өнгөтэй болно. Ийм биш бол $\Delta y_2 y_3 y_4$ нь 3 өнгөтэй болно. ↓

$$P_2(S_{17}) = A_1 \cup A_2 \cup A_3 \quad (2)$$

энд $\{x, y\} \in A_k \Leftrightarrow x, y$ хоёр k дугаар сэдвээр харилцсан гэвэл бодлогын нөхцөл нь энэхүү (2) хуваалтыг өгөх тул $17 \geq N(3, 3, 3; 2)$ боллоо. $N(3, 3, 3; 2) > 16$ гэдгийг батлахын тулд 16 оройтой бүтэн графын нэг өнгийн Δ агуулаагүй 3-будалтыг байгуулах нь бас амаргүй асуудал байдаг.

Бодлого 2(Шур. И 1916). [16] -тоонуудыг 3 өнгөөр будахад (3 ангид хуваахад) $x + y = z$ тэгшитгэл 1 өнгийн шийдтэй гэж үзүүл.

↑ $\theta : [16] \rightarrow [3]$ өгсөн будалт нь $P_2([17]) = A_1 \cup A_2 \cup A_3$, энд $\{x, y\} \in A_k \Leftrightarrow \theta|x - y| = k$ гэсэн хуваалтыг өгнө.

Бодлого 1-ээр $17 \geq N(3, 3, 3; 2)$ гэж гарсан тул Рамсейн теоремоор

$\exists s, \exists X = \{i, j, k\} \subseteq [17], i < j < k, P_2(X) \subseteq A_s$ буюу $s = \theta(j - i) = \theta(k - j) = \theta(k - i)$ ба $j - i + k - j = k - i$. ↓

$N(q_1, \dots, q_t; 1) = \sum q_i - (t - 1)$ болохыг (1) -ээс мэднэ.

$N(4, 4, 4; 2) \geq 128$ болох нь батлагдсан. $N(q_1, \dots, q_t; 2)$ -ийн томьёо олдоогүй байна. $N(q_1, \dots, q_t; 2) = N$ бол N оройтой бүтэн графын ирмэгүүдийг t өнгөөр яаж ч будсан ямар нэг i -ийн хувьд i -өнгө бүхий q_i -бүтэн дэд граф олдоно гэж Рамсейн Теоремоос шууд гарна.

Бодлого 3. $\forall n$ -ийн хувьд $\exists N = N(n)$, аль ч гурав нь нэг шулуун дээр үл орших хавтгайн N цэгийн хувьд эдгээрийн аль нэг n дээр нь оройтой гүдгэр n өнцөгт оршино.

↑ 1) өгөгдсөн n -өнцөгтийн оройнуудаас зохиож болох бүх дөрвөн өнцөгтүүд гүдгэр бол уг n -өнцөгт гүдгэр байна (үүнийг индукцээр хялбар батална). $N = N(n, 5; 4)$ ба хавтгайд ерөнхий байршилтай N цэг (S_N) өгөгдсөн байг. S_n -ийн бүх 4 өнцөгтүүдийн олонлогийг гүдгэр (A_1) ба хотгор (A_2) гэсэн 2 ангид хуваая: $P_4(S_n) = A_1 \cup A_2$ Тэгвэл Рамсейн теоремоор эсвэл $\exists X \subseteq S_N$, $|X| = n$ ба $P_4(X) \subseteq A_1$, энэ үед X нь 1) -ээр гүдгэр n -өнцөгтийг өгнө. Эсвэл $\exists X \subseteq S_N$, $|X| = 5$ ба $P_4(X) \subseteq A_2$ гэтэл энэ тохиолдол боломжгүй юм. ↓

$P_2(S_n) = A_1 \cup A_2$, $\{i, j\} \in A_1 \Leftrightarrow [ij]$ хөх хэрчим $\Leftrightarrow i, j$ хоёр танил,

$\{i, j\} \in A_2 \Leftrightarrow [ij]$ улаан хэрчим $\Leftrightarrow i, j$ хоёр танил биш,

$n = N(5, 3; 2)$ гэвэл $S_n\{x_1, x_2, \dots, x_n\}$ -ийн цэгүүдийг 2 өнгөөр холбоход эсвэл хөх 5 хошуу олдоно, эсвэл улаан Δ олдоно, г.м. олон янзаар томъёолж болно.

Теорем 2(Ширшов А.И, 1957). $\forall k, s, n \in \mathbb{N}$ -үүдийн хувьд $\exists N = N(k, s, n)$: k симболоос зохиосон N үрттай дурын үгэнд эсвэл дараалсан s адил дэд үг байна, эсвэл n -хуваагдах дэд үг байна(Олонлог, 2011 тусгай дугаар, х.51-57).

Бодлого 4(Ширшов).

A, B, C саванд харгалзан a, b, c литр ус байв. $a, b, c \in \mathbb{N}$. Сав тус бүрийн эзлэхүүнийг хангалттай их гэж үзээд аль нэг саванд байгаа устай тэнцүү хэмжээтэй усыг өөр аль нэг савнаас нь юүлж хийх замаар аль нэг савыг нь хоосолж болохыг батал. (Олонлогийн Математик цоморлиг 2007-2008, х.231)

↑ $0 < a \leq b \leq c$ гэе. $b = ad + r$, $0 \leq r < a$.

$d = 2^{k_1} + \dots + 2^{k_s}$, $k_1 < k_2 < \dots < k_s$ бол A -руу C -ээс эхлээд $(1 + 2 + 2^2 + \dots + 2^{k_1-1})a$ литр усыг юүлж дараа нь B -ээс $2^{k_1}a$ усыг хийвэл A -д $2^{k_1+1}a$ литр устай болно, дараа нь C -

ээс $(2^{k_1+1} + 2^{k_1+2} + \dots + 2^{k_2-1})a$ л ус хийж дараа нь B -ээс 2^{k_2} л ус хийнэ г.м. B -ээс A -руу da л ус хийхэд B -д r литр ус үлдэнэ, ө.х. (a, b, c) төлөвөөс (a_1, b_1, c_1) төлөвд шилжихэд $\min(a_1, b_1, c_1) < \min(a, b, c)$ болсон. Энэ үед C -ээс A -руу юүлсэн ус B -ээс A -руу юүлсэн уснаас ихгүй тул энэ үйлдлийг гүйцэтгэж чадна. (a_1, b_1, c_1) төлвөөс цааш яг саяных шиг ажиллаж $\min(a_1, b_1, c_1)$ багасгаж чадна, эцэстээ 0 болгож чадна. ↓

Ширшовын теоремын Йорданы ба Ли алгебрт зориулсан хувилбарыг алдарт математикч Е.И.Зельманов 1980-90-ээд онуудад хийж бүлгийн онол, Ли ба Йорданы алгебрийн хамгийн хүнд асуудлуудыг шийдсэн, харин баруун альтернатив алгебрт зориулсан хувилбарыг миний бие 1984 онд хийж К.А.Жевлаковын асуудлыг шийдсэн болно.

Дараа нь эндээсээ санаа авч Ширшов багшийн Бодлого 4-тай юмуу эсвэл Шүрийн Бодлого 2-той төстэйгээр n -ийн ямар утгад $1, 2, \dots, n$ тоонуудыг дурын аргаар 3 ангид хуваахад хуваалтын аль нэг ангид нь $x + y = z$ байх 3 ялгаатай тоо x, y, z олдохыг баталж болох вэ? гэсэн асуулт тавьж $n = 1000$ үед 1984 оны МО-ийн 3-р даваанд дэвшүүлж, манай нэрт математикч П.Энхболд нар 1000-г 49 болтол багасгаж байж билээ. Харин $n = 24$ доод торгон зааг болохыг миний шавь нар компьютер ашиглан тогтоосон боловч цэвэр математик баталгаа нь одоо хүртэл алга байгаа нь баруун альтернатив алгебрийн тохиолд асуудал хир гүнзгий болохыг хэлээд байх шиг.

2009 оны 7 сард Германд болсон ОУМО-50 д хүндэт зочноор уригдсан ОУМО-ийн удаа дараагийн алтан медальт, алдарт математикч Б.Боллабаш(Унгар, Англи), Л.Ловас(Унгар, Америк), Ж.Ёкос(Франц), С.Смирнов(Орос, Швейцарь), Т.Тао(Австраль, АНУ), Т.Гауэрс(Англи) нар өөрсдийн хамгийн шилдэг ажлуудаа Рамсейн теоремд тулгуурлан хийснээ тайлагнаж байв.

**МОНГОЛ ХҮМҮҮНИЙ ХИЙМОРЬ ЛУНДААГ
ДЭЛХИЙД ГАЙХУУЛСАН ЗАНГАРАГАТАЙ
МАТЕМАТИКЧИД ТӨРӨХ БОЛТУГАЙ.**

3 Монголын математикийн XLVII олимпиад

3.1 ММО-47, VII ангийн III даваа

Н.Аргилсан (МУБИС)

VII-A1 (Н.Аргилсан). $A = \frac{1}{1 \cdot 2} + \frac{1}{3 \cdot 4} + \dots + \frac{1}{2011 \cdot 2012}$ ба
 $B = \frac{1}{1007 \cdot 2012} + \frac{1}{1008 \cdot 2011} + \dots + \frac{1}{2012 \cdot 1007}$ бол $\frac{A}{B}$ утгыг ол.

VII-A2 (Ц.Нямдаваа). x, y, z нь хос хосоороо харилцан анхны натурал тоонууд бол $\frac{(x+y)(y+z)(z+x)}{xyz}$ илэрхийллийн бүх бүхэл тоон утгыг ол.

VII-A3 (Э.Азжаргал). ABC гурвалжны AB тал дээр E цэгийг, BC талын үргэлжлэл дээр F цэгийг $AE = BF$ байхаар авав. $\angle FEC = 90^\circ$ бол $\angle ACE = ?$

VII-B1 (Н.Аргилсан). $(x+y)^2 = (x-2)(x+2)$ тэгшитгэлийн бүх бүхэл тоон шийдийг ол.

VII-B2 (Н.Дайвий-Од). Үржвэр нь ч, нийлбэр нь ч n -тэй тэнцүү байх n ширхэг бүхэл тоо олддог бол n -ийг "сайн" тоо гье. Тэгвэл $4k+1$ ($k \geq 0$), 4ℓ ($\ell \geq 2$) хэлбэрийн бүх тоонууд сайн тоо болохыг харуул.

VII-B3 (Б.Эрдэнэбаяр). $a > b$ байх эерэг бодит a, b тоонуудын хувьд $a + \frac{1}{b(a-b)} \geq 3$ тэнцэтгэл биш биелэхийг харуул.

VII-A1:

$$\begin{aligned} A &= \left(1 - \frac{1}{2}\right) + \left(\frac{1}{3} - \frac{1}{4}\right) + \dots + \left(\frac{1}{2011} - \frac{1}{2012}\right) \\ &= \left(1 + \frac{1}{2} + \dots + \frac{1}{2012}\right) - 2 \left(\frac{1}{2} + \frac{1}{4} + \dots + \frac{1}{2012}\right) \end{aligned}$$

$$\begin{aligned}
&= \left(1 + \frac{1}{2} + \cdots + \frac{1}{2012}\right) - \left(1 + \frac{1}{2} + \cdots + \frac{1}{1006}\right) \\
&= (1-1) + \left(\frac{1}{2} - \frac{1}{2}\right) + \cdots + \left(\frac{1}{1006} - \frac{1}{1006}\right) + \\
&\quad + \frac{1}{1007} + \cdots + \frac{1}{2012} = \frac{1}{1007} + \cdots + \frac{1}{2012} \\
2A &= \left(\frac{1}{1007} + \frac{1}{2012}\right) + \cdots + \left(\frac{1}{1008} + \frac{1}{2011}\right) + \\
&\quad + \cdots + \left(\frac{1}{2012} + \frac{1}{1007}\right) = 3019 \\
&\quad \left(\frac{1}{1007 \cdot 2012} + \frac{1}{1008 \cdot 2011} + \cdots + \frac{1}{2012 \cdot 1007}\right) \\
&= 3019 \cdot B \Rightarrow \frac{A}{B} = \frac{3019}{2}
\end{aligned}$$

VII-A2: а) $x = y = z$ бол хос хосоороо харилцан анхных гэдгээс $x = y = z = 1$ байна. Эндээс

$$\frac{(x+y)(y+z)(z+x)}{xyz} = n$$

гэвэл $n = 8$ байна.

б) $x = y = 1$ ба $z > 1$ байг.

$$n = \frac{2(1+z)(z+1)}{z} = \frac{2(z^2 + 2z + 1)}{z} = 2\left(z + 2 + \frac{1}{z}\right) \in \mathbb{Z}$$


гэдгээс $z = 1, z = 2$ болно. Энэ үед $n = 8$ ба $n = 9$ болно.

в) Одоо бүгдээрээ ялгаатай гэе. $x < y < z$ гэж үзэж болно. $(x+y)(y+z)(z+x) = n \cdot xyz$ гэдгээс 2 талыг нь z -ээр жишвэл $x + y : z$. Үүнтэй адил $x + z : y$ байна. Нөгөө талаас $x + y < 2z$ байна. $x + y = mz$, $x + z = ky$ гэж үзвэл $x + y < 2z \Rightarrow mz < 2z \Rightarrow m < 2 \Rightarrow m = 1$ байна. Иймд

VII-B2: Үржвэр нь ч нийлбэр нь ч n -тэй тэнцүү байх n ширхэг бүхэл тоо олддог бол n -г "Сайн тоо" гээ. Тэгвэл

а). $4k + 1 (k \geq 0)$

б). $4l (l \geq 2)$ хэлбэрийн тоонууд бүгд сайн тоо болохыг харуулъя.



а). $1; \underbrace{-1; -1; \dots -1}_{2k}; \underbrace{1; 1; \dots 1}_{2k};$

Эдгээр тоонууд бодлогын нөхцөлийг хангана.

б). $l - \text{тэгш бол}$
 $l; 4; \underbrace{-1; -1; \dots -1}_{\frac{l+2}{2}}; \underbrace{1; 1; \dots 1}_{\frac{7l-6}{2}};$

$l - \text{сондгой бол}$

1. $A \frac{l+1}{2} E \text{ тэгш үед } l; 2; 2; 2; \dots 2; \frac{1}{2}; -\frac{1}{2} \underbrace{-1; -1; \dots -1}_{\frac{l-3}{2}}; \underbrace{1; 1; \dots 1}_{\frac{7l-11}{2}};$

2. $\frac{l+1}{2} \text{ сондгой үед } l; 2; 2; 2; \dots 2; \frac{1}{2}; -\frac{1}{2}; \underbrace{-1; -1; \dots -1}_{\frac{l+1}{2}}; \underbrace{1; 1; \dots 1}_{\frac{7l-13}{2}};$

тоонууд бодлогын нөхцөлийг хангана.

VII-B3: $a > b > 0$ бол $a + \frac{1}{b(a-b)} \geq 3$ тэнцэтгэл бишийг баталъя. Тэнцэтгэл бишийн зүүн гар талд b -г нэмж, хасаж өгөөд 3-н тооны хувьд Кошийн тэнцэтгэл биш бичвэл шууд гарна. Харин Коши хэрэглэхгүйгээр хэрхэн батлахыг авч үзье. Ижил хуваарь өгч b -ийн хувьд эмхэтгэвэл

$$ab(a-b) + 1 \geq 3b(a-b) \Rightarrow a^2b - ab^2 + 1 \geq 3ab - 3b^2 \Rightarrow$$

$$(3-a)b^2 + (a^2-3a)b + 1 \geq 0$$

Хэрэв $a \geq 3$ бол анхны тэнцэтгэл биш нь илэрхий байна. Иймд $a < 3$ гэж үзье. $f(b) = (3-a)b^2 + (a^2-3a)b + 1$ гэсэн b -хувьсагчийн хувьдах кв 3-н гишүүнтийг авъя. $3-a > 0$ учир график нь дээшээ харсан прабол байна. Иймд дискриминантыг нь авч үзье. Хэрэв

$D \leq 0$ гэж баталбал тэнцэтгэл биш батлагдана.

$$\begin{aligned} D &= (a^2 - 3a)^2 - 4(3 - a) \cdot 1 = a^2(3 - a)^2 - 4(3 - a) \\ &= (3 - a)(a^2(3 - a) - 4) = (3 - a)(3a^2 - a^3 - 3 - 1) \\ &= (3 - a)(3(a^2 - 1) - (a^3 + 1)) \\ &= (3 - a)(3(a - 1)(a + 1) - (a + 1)(a^2 - a + 1)) \\ &= (3 - a)(a + 1)(-a^2 + 4a - 4) \\ &= -(3 - a)(a + 1)(a - 2)^2 \leq 0 \quad (a < 3 \text{ учир}) \end{aligned}$$

Иймд тэнцэтгэл биш нь батлагдлаа.

3.2 ММО-47, VIII ангийн III даваа

Н.Аргилсан (МУБИС)

VIII-A1 (Ц.Нямдаваа). $p^3 - q^5 = (p + q)^2$ байх бүх (p, q) хос анхны тоонуудыг ол.

VIII-A2 (Н.Аргилсан). n нь 2-ын зэрэгт хэлбэртэй бичигддэг ба цифрүүдийнх нь байрыг сольж өөр ялгаатай 2-ын зэрэгт хэлбэрт бичигдэх тоог үүсгэж болдог байх n натурал тоо оршин байх уу?

VIII-A3 (Н.Дайвий-Од). Нэгж радиустай дугуйг гадна талаас нь нэгж талтай квадратуудаар дараахи хоёр нөхцөлийг нэгэн зэрэг хангадаг байхаар тойруулан хүрээлж болохыг батал. Үүнд:

1. Квадрат бүр дугуйг зөвхөн оройгоороо шүргэнэ.
2. Хөрш квадратууд зөвхөн нэг нэг оройгоороо холбогдоно.

VIII-B1 (Н.Аргилсан). a, b, c эерэг бодит тоонуудын хувьд

$$\frac{3}{8} \left(\frac{1}{a} + \frac{1}{b} + \frac{1}{c} \right) > \frac{1}{2a+b} + \frac{1}{2b+c} + \frac{1}{2c+a}$$

тэнцэтгэл биш биелэхийг батал.

VIII-B2 (Н.Дайвий-Од). Үржвэр нь ч, нийлбэр нь ч n -тэй тэнцүү байх n ширхэг бүхэл тоо олддог бол n -ийг "сайн" тоо гэе. Сайн тоо төгсгөлгүй олон олдохыг харуул.

VIII-B3 (Э.Азжаргал). Анги 30 сурагчтай ба сурагч бүрийн ангид байгаа найзын тоо хоорондоо тэнцүү байв. Өөрийнхөө бүх найзуудаас сурлагаар илүү сурагчийг "сайн сурагч" гэж нэрлэе. Сайн сурагчийн тоо хамгийн ихдээ хэд байж болох вэ? (Ямар ч хоёр сурагчийн хувьд нэг нь сурлагаар илүү байна)

VIII-A1: Тэгшитгэлээс $p > q$ байх нь илэрхий. p ба q -г 3-т хуваахад өгөх үлдэгдлүүдээр шалгая.

a) $p \equiv 1(3)$ ба $q \equiv 1(3)$ байг. $\Rightarrow p^3 - q^5 \equiv 0(3)$. Харин $(p+q)^2 \equiv 1(3)$ тул шийдгүй.

b) $p \equiv 1(3)$ ба $q \equiv 2(3)$ байг. $\Rightarrow p^3 - q^5 \equiv 1 - 2^5 \equiv 1 - (-1) \equiv 2(3)$. Харин $(p+q)^2 \equiv 0(3)$ тул шийдгүй.

c) $p \equiv 2(3)$ ба $q \equiv 1(3)$ байг. $\Rightarrow p^3 - q^5 \equiv 2^3 - 1^5 \equiv 7 \equiv 1(3)$. Харин $(p+q)^2 \equiv 0(3)$ тул шийдгүй.

d) $p \equiv 2(3)$ ба $q \equiv 2(3)$ байг. $\Rightarrow p^3 - q^5 \equiv -1 - (-1) \equiv 0(3)$. Харин $(p+q)^2 \equiv (2+2)^2 \equiv 1(3)$ тул шийдгүй.

Иймд p, q -ийн ядаж нэг нь 3-д хуваагдах болж байна. p анхны тоо $p \equiv 0(3)$ гэе. Тэгвэл $p^3 - q^5 = (p+q)^2 \Rightarrow -q^5 = q^2(3)$ буюу өөрөөр хэлбэл $q^5 + q^2 \equiv 0(3)$ болно. $\Rightarrow q^2(q^3 + 1) \equiv 0(3)$ буюу $q^2 \equiv 0(3)$ эсвэл $q^3 + 1 \equiv 0(3)$ байна. Хэрэв $q^2 \equiv 0(3)$ бол q -анхны тоо $\Rightarrow q = 3$ байна. p -анхны тоо тул $p = 3$ болно. Гэвч $p > q$ тул энэ нь шийд биш. Хэрэв $q^3 + 1 \equiv 1(3)$ ба $p > q$ гэдгээс $p = 3$ $q = 2$ гэсэн утгыг авч болно. Гэвч бас тэгшитгэлийн шийд биш болно. Иймд $q = 3$ байг. $p^3 - 243 = (p+3)^2$ ба $p^3 \equiv p^2(3)$ байна.

$\Rightarrow p^2(p-1) \equiv 0(3)$ ба $p^2 \not\equiv 0(3)$ тул $(p-1) \equiv 0(3)$ байх буюу $p=7$ гэсэн анхны тоо байна.


Өөр шийдгүйг харуулъя. $p^3 - 243 = p^2 + 6p + 9 \Rightarrow p^3 - p^2 - 6p - 252 = 0$.

$p^2(p-1) - 6(p-1) - 258 = 0 \Rightarrow (p^2 - 6)(p-1) = 258. \Rightarrow p > 7$ байх анхны тоон шийдгүй нь харагдана. Иймд $(p=7, q=3)$ гэсэн ганц шийдтэй.

VIII-A2: Энэ тоог a -гэе. $a = 2^n$ гэж бичигдэнэ. Цифрүүдийн байрыг сольж $b = 2^m$ тоог үүсгэж байдаг гэе. Тэгвэл $b = 2a$ эсвэл $b = 2^2 \cdot a$ эсвэл $b = 2^3 \cdot a$ байх боломжтой (2^4 -ээс их тоогоор үржвэл орон нэмэгдэх тул үржиж болохгүй).

$(b-a)$ -тоог авч үзье. $(b-a) = a$ эсвэл $(b-a) = 3a$ эсвэл $(b-a) = 7a$ болно. Гэвч $b-a:9$ ба харин $a, 3a, 7a$ тоонуудын аль нь ч 9-д хуваагдахгүй. Иймд a -натурал тоо олдохгүй.

VIII-A3: ◀ Тойргйн төвийг O , аль нэг квадрат тойрогтой шүргэх пэгийг A_1 , түүний дараагийн квадрат тойрогтой шүргэх пэгийг A_2 , дараагийнхыг нь A_3 , гэх мэт тэмдэглэе.



Хэрэв A_1, A_2 , цэгт шүргэдэг квадратуудын хоорондоо холбогдож байгаа ерөнхий оройг B_1 , дараагийн хосын ерөнхий оройг B_2 , гэх мэтчилэн тэмдэглэвэл эхний 2 квадрат OB_1 шулууны хувьд, дараагийн 2 квадрат OB_2 шулууны хувьд, тэгш хэмтэй учир $OA_1B_1A_2, OA_2B_2A_3$ дөрвөн өнцөгтүүд ромбо болно.

Иймд OA_1 нь A_2B_1 -тэй, OA_3 нь A_2B_2 -тэй параллель учир тэдгээрийн хоорондох 90° өнцөг болно ($\angle A_1OA_3 = 90^\circ$). Цаашид $\angle A_3OA_5, \angle A_5OA_7, \angle A_7OA_9$ гэдгээс $A_1 = A_9$ болно. Ингээд 8-н квадратаар дээрх нөхцөл хангаж байхаар хүрээлж болдог нь батлагдлаа. ►

VIII-B1: $\left(a + \frac{b}{2}\right)^2 \geq 4 \cdot a \cdot \frac{b}{2} = 2ab$ тэнцэтгэл бишийг ашиг-

лая. $\frac{a + \frac{b}{2}}{ab} \geq \frac{2}{a + \frac{b}{2}} \Rightarrow \frac{1}{b} + \frac{1}{2a} \geq \frac{4}{2a + b}$ болно. Үүнтэй адил

$$\frac{1}{c} + \frac{1}{2b} \geq \frac{4}{2b + c}, \quad \frac{1}{a} + \frac{1}{2c} \geq \frac{4}{2c + a}$$

$$\Rightarrow \frac{1}{b} + \frac{1}{2a} + \frac{1}{c} + \frac{1}{2b} + \frac{1}{a} + \frac{1}{2c} \geq 4 \left(\frac{1}{2a + b} + \frac{1}{2b + c} + \frac{1}{2c + a} \right)$$

$$\Rightarrow \frac{3}{2} \left(\frac{1}{a} + \frac{1}{b} + \frac{1}{c} \right) \geq 4 \left(\frac{1}{2a + b} + \frac{1}{2b + c} + \frac{1}{2c + a} \right)$$

Кошийн тэнцэтгэл бишийн тэнцэлдээ хүрэх нөхцлийг санавал

$a = \frac{b}{2}, b = \frac{c}{2}, c = \frac{a}{2}$ буюу $b = 2a, c = 2b, a = 2c$ гэдгээс $c = 2 \cdot 2a = 4a = 4 \cdot 2c = 8c$ буюу $c = 0$ болоход хүрнэ. Иймд тэнцэлдээ хүрэхгүй тул $\frac{3}{8} \left(\frac{1}{a} + \frac{1}{b} + \frac{1}{c} \right) > \frac{1}{2a + b} + \frac{1}{2b + c} + \frac{1}{2c + a}$

VIII-B2: (7-р ангийн B2 бодолтыг хар.)

VIII-B3: Ангийн 30 сурагч 2, 2-оор найз гэж үзвэл 15 сайн сурагч олдоно. Одоо 15-аас олон сайн сурагч олдохгүй гэж харуулъя. Эсэргээс нь 16 сайн сурагч олддог гээ. 1 сайн сурагч m-ширхэг найзтай гэвэл сайн сурагчдын найзын тоо 16m болно. Үлдсэн 14 сурагч нь сайн сурагчидтай найзлах тоо m-ээс их болох хэрэгтэй болно. Өөрөөр хэлбэл 1 сайн сурагчаас m-ширхэг сум сайн биш сурагчидруу очиход 1 сайн биш сурагч дээр m-ээс олон сурагч очих учир зөрчинө. Иймд хамгийн ихдээ 15 сайн сурагчтай байна.

3.3 ММО-47, VIII ангийн IV даваа

Ч.Гантөмөр

VIII-A1 (Н.Аргилсан). Аливаа эерэг a, b, c бодит тоонуудын хувьд
$$\frac{1}{ab+c} + \frac{1}{bc+a} + \frac{1}{ac+b} \geq \frac{24}{(a+b+c+1)^2}$$
 тэнцэтгэл биш биелэхийг харуул.

VIII-A2 (Н.Дайвий-Од). Хот 472011 хүнтэй ба хүн бүр өөрийн дуртай дугаар бүхий гар утас барьдаг (ямар ч 2 дугаар давхцахгүй ба натурал тоогоор дугаарлана). Хэрэв хүн бүр өөрийнхөө утасны дугаарын хуваагч дугаартай утас барьдаг хүнтэй найз бол ижил тооны найзтай 2 хүн олдохыг харуул (Хүн бүр 1 дугаар эзэмшинэ, А нь В-тэй найз бол В нь мөн А-тай найз байна).

VIII-A3 (М.Батбилэг). Хавтгай дээр аль ч 3 нь нэг цэгээр огтлолцохгүй, аль ч 2 нь параллель биш 47 шулуун зурав. Аль нэг шулуунтай параллель шулуун зурах замаар нийт 2011 шулуун зурагдахад хавтгай хамгийн олондоо хэдэн хэсэгт хуваагдах вэ?

VIII-B1 (Б.Ганбат) $x^6 + 3x^3 + 1 = y^4$ тэгшитгэлийн бүх бүхэл тоон шийдийг ол.

VIII-B2 (Э.Азжаргал). В, С цэгүүд AD диаметртэй хагас тойрог дээр оршино. Е ба F цэгүүд харгалзан В ба С цэгүүдийн AD хэрчим дээрхи проекц болно. АВ ба DC шулуунууд Р цэгт, ЕС ба BF шулуунууд Q цэгт огтлолцоно. Тэгвэл $PQ \perp AD$ гэж батал.

VIII-B3 (Э.Энхзаяа) n -ширхэг ялгаатай бодит тоо өгөгдөв. Тэгвэл эдгээр тоонуудаас хэдэн тоог, уг сонгож авсан тоонуудын нийлбэр дээр ямар нэг бүхэл тоог нэмэхэд гарах тоо нь модулиараа $\frac{1}{n+1}$ -ээс хэтрэхгүй байхаар сонгож авч болохыг батал.

VIII-A1:

$(u+v)^2 \geq 4uv \Leftrightarrow \frac{u+v}{uv} \geq \frac{4}{u+v} \Leftrightarrow \frac{1}{u} + \frac{1}{v} \geq \frac{4}{u+v}$ гэсэн илэрхий тэнцэтгэл бишээс $x, y, z > 0$ бол (*)

$$\frac{1}{x} + \frac{1}{y} + \frac{1}{z} \geq 2 \left(\frac{1}{x+y} + \frac{1}{y+z} + \frac{1}{z+x} \right)$$

тэнцэтгэл биш биелэх нь мөрдөн гарна.

(*) тэнцэтгэл бишд $x = ab+c$, $y = bc+a$, $z = ac+b$ гэж орлуулбал

$$\begin{aligned} & \frac{1}{ab+c} + \frac{1}{bc+a} + \frac{1}{ac+b} \\ & \geq 2 \left(\frac{1}{ab+bc+a+c} + \frac{1}{bc+ca+a+b} + \frac{1}{ac+ab+b+c} \right) \\ & = 2 \left(\frac{1}{(a+c)(b+1)} + \frac{1}{(a+b)(c+1)} + \frac{1}{(b+c)(a+1)} \right) \\ & \geq 2 \left(\frac{4}{(a+c+b+1)^2} + \frac{4}{(a+b+c+1)^2} + \frac{4}{(b+c+a+1)^2} \right) \\ & = \frac{24}{(a+b+c+1)^2} \end{aligned}$$

болж батлах зүйл гарна. Энд $(a+b)(c+1) \leq \left(\frac{(a+b)+(c+1)}{2} \right)^2$ гэсэн Кошийн тэнцэтгэл бишийг ашиглав. Өгөгдсөн тэнцэтгэл биш нь $a = b = c = 1$ байхад тэнцэлдээ хүрнэ.

VIII-A2: Энэ бодлого нь дараах энгийн чанараас шууд мөрдөн гарна.

Теорем: Аливаа ердийн графын хувьд оройн зэргүүд нь тэнцүү хоёр орой олдоно. Үнэхээр n цэгийн заримыг хэрчмээр холбоход ижил тооны хэрчим гарсан 2 цэг олдоно гэдгийг Дирихлейн зарчим ашиглан хялбархан харж болно: Аль ч цэгээс гарсан хэрчмийн тоо $\in \{0, 1, \dots, n-1\}$ ба хэрэв уг тоо нь 0-тэй тэнцүү бол

гарсан хэрчмийн тоо нь $n-1$ тэй тэнцүү байх орой олдохгүй. Хэрэв гарсан хэрчмийн тоо нь $n-1$ тэй тэнцүү цэг байвал хэрчим гараагүй орой олдохгүй. Иймд цэгээс гарсан хэрчмүүдийн тооны авч болох утгууд нь ихдээ $n-1$ ширхэг байх ба эдгээрийг "хайрцаг" гэж сэтгээд n цэгээ "туулай" гэж авахад аль нэг хайрцагт дор хаяж 2 туулай орно буюу ижил тооны хэрчим гарсан 2 цэг олдоно. Одоо бид хотын хүмүүсээ цэг гээд хоорондоо найз хосыг хэрчмээр холбосон гэж сэтгэвэл дээрх чанараар ижил тооны найзтай 2 хүн олдох ажээ.

VIII-A3: Эхэлж татагдсан 47 шулуунаа 1-47 хүртэл дугаарлая. a_i -ээр i -р шулуунтай параллель шулууны тоог тэмдэглэе. ($i = \overline{1, 47}$). Одоо нийт хэсгийн тоог тоолъё. Хэдэн шулуун татагдсан байг. Шинээр нэмж ямар нэг шулуун татахад уг шулуун түүнтэй параллель биш бүх шулуунтай огтлолцоно. Хэрэв татагдсан шулуунтай k шулуун огтлолцдог бол уг шулуун нийт $k+1$ хэсэгт хуваагдах ба хуваагдсан хэсэг бүр ямар нэгэн шинэ хэсгийн нэг тал болно. Иймд хэсгийн тоо $k+1$ -ээр нэмэгдэнэ. Нийт хэсгийн тоог тооцвол (Энд $a_1 + \dots + a_{47} = 2011$)

$$\begin{aligned} & a_1(a_2 + \dots + a_{47}) + a_2(a_3 + \dots + a_{47}) + a_3(a_4 + \dots + a_{47}) \\ & + \dots + a_{46} \cdot a_{47} + a_1 + \dots + a_{47} + 1 \\ & = \sum_{1 \leq i < j \leq 47} a_i a_j + \sum_{i=1}^{47} a_i + 1 = 2012 + \sum_{1 \leq i < j \leq 47} a_i a_j \end{aligned}$$

болно. Одоо бид $A = \sum_{1 \leq i < j \leq 47} a_i a_j$ -ын хамгийн их утгыг олъё.

$A = \frac{1}{2} [(\sum a_i)^2 - \sum a_i^2] = \frac{1}{2} [(2011)^2 - \sum a_i^2]$ тул A -ын ХИУ-ыг олох нь $B = \sum a_i^2$ -ын ХБУ-ыг олохтой адил юм.

$x^2 + y^2 \geq \frac{1}{2}(x+y)^2$ тул B нь ХБУ-аа a_i -үүд нь хоорондоо тэнцүү үед л авна. a_i -үүд нь натураль тоо тул $(2011 = 47 \cdot 42 + 37)$,

$B \geq 37 \cdot 43^2 + 10 \cdot 42^2$ болно. Иймд нийт хэсгийн тоо хамгийн

ихдээ $2012 + \frac{1}{2} [(2011)^2 - (37 \cdot 43^2 + 10 \cdot 42^2)]$ болно.

VIII-B1:

$$x^6 + 3x^3 + 1 = y^4 \Leftrightarrow (x^3 + 1)^2 + (x^3 + 1) = y^4 + 1$$

$$\Leftrightarrow (2x^3 + 3)^2 - 4y^4 = 5 \Leftrightarrow (2x^3 - 2y^2 + 3)(2x^3 + 2y^2 + 3) = 5$$

болно. $5 = 1 \cdot 5 = (-1)(-5) = 5 \cdot 1 = (-5)(-1)$ гэдгийг бодолцвол

$$\begin{cases} 2x^3 - 2y^2 + 3 = 1 \vee -1 \vee 5 \vee -5 \\ 2x^3 + 2y^2 + 3 = 5 \vee -5 \vee 1 \vee -1 \end{cases} \text{ гэсэн 4 систем гарах ба эдгээ-}$$

рийг бодсоноор

$$(x, y) \in \{(0, 1), (0, -1)\} \text{ гэсэн хоёр л шийд олдоно.}$$

Нэмэлт. Дээрх тэгшитгэлийг өөрөөр, $x^3 = z$ гэж орлуулбал $z^2 + 3z + (1 - y^4) = 0$ болох ба z -ийн хувьд квадрат тэгшитгэл гэж санавал түүний дискриминант $D = 9 - 4(1 - y^4) = 0$ бүтэн квадрат өөрөөр хэлбэл $5 + 4y^4 = t^2$ байх ба $\Leftrightarrow 5 = (t - 2y^2)(t + 2y^2)$ болж ахин дээрх бодолтын адил үржигдэхүүнд задлах замаар бодлогийг бодож болохыг тэмдэглэе.

VIII-B2: $\angle ABD = \angle ACD = 90^\circ$ байна. P -г дайрсан AD -тэй параллель шулуун EB ба FC шулуунуудтай харгалзан K ба L цэгээр огтлолцдог гэе. Түүнчлэн Q -г дайрсан AD -тэй параллель шулуун EB ба FC шулуунуудтай харгалзан M ба N цэгээр огтлоно. $KL = MN$ байх нь ойлгомжтой

$\triangle BKP \sim \triangle BED$, $\triangle APC \sim \triangle DPB$ ба $\triangle CLP \sim \triangle AFC$ гэд-

гээс

$$\frac{KP}{BE} = \frac{BP}{BD} = \frac{PC}{AC} = \frac{PL}{CF} \Rightarrow (*)$$

$$\frac{KP}{BE} = \frac{BE}{BE} \text{ болно. } \triangle BQE \sim \triangle FQC \Rightarrow (**)$$

$$\frac{PL}{MQ} = \frac{CF}{BE} \text{ болно. } (*) \text{ ба } (**)$$

$$\Rightarrow \frac{KP}{PL} = \frac{BE}{CF} = \frac{MQ}{QN} \Rightarrow \frac{KP}{PL} + 1 = \frac{MQ}{QN} + 1$$

$$\Leftrightarrow \frac{KP + PL}{PL} = \frac{MQ + QN}{QN} \Leftrightarrow \frac{KL}{PL} = \frac{MN}{QN} \Rightarrow PL = QN$$

болж $PQ // LN$ буюу $AD \perp PQ$ болов.

VIII-B3: (Энхзаяа)

Бодолт: $\triangleright$ Илүү ерөнхий бодлого авч үзье. Дурын n ширхэг бодит тоонуудаас тогтох

$X = \{x_1, x_2, \dots, x_n\}$ олонлог өгөгдсөн бол $|m + \sum_{s \in S} s| \leq \frac{1}{n+1}$ байх

m бүхэл тоо ба $S \subseteq X$ дэд олонлог ($S \neq \emptyset$) олдохыг баталъя.

Юуны өмнө x бодит тооноос ихгүй хамгийн их бүхэл тоо $[x]$ -г x -ийн бүхэл хэсэг гэх ба $\{x\} = x - [x]$ тоог x -ийн бутархай хэсэг гэдгийг тэмдэглэе. $\{x_1\}, \{x_1 + x_2\}, \dots, \{x_1 + x_2 + \dots + x_n\}$ тоонуудыг авч үзье. Хэрэв эдгээр тоонуудын аль нэг нь $\left[0, \frac{1}{n+1}\right]$ эс-

вэл $\left[\frac{n}{n+1}, 1\right]$ хэрчимд ордог бол бодлого шууд бодогдоно. Иймд дээрх тоонууд бүгд дээр дурдсан 2 хэрчимд ордоггүй байг. Тэгвэл

$$\left[\frac{1}{n+1}, \frac{2}{n+1}\right], \left[\frac{2}{n+1}, \frac{3}{n+1}\right], \dots, \left[\frac{n-1}{n+1}, \frac{n}{n+1}\right]$$

гэсэн $n-1$ хэрчимийг авахад $\{x_1\}, \{x_1 + x_2\}, \dots, \{x_1 + x_2 + \dots + x_n\}$

гэсэн n тооноос Дирихлейн зарчмаар нэг хэрчимд орох 2 тоо олдоно. Тэдгээр нь $\{x_1 + \dots + x_k\}$ ба $\{x_1 + x_2 + \dots + x_{k+m}\}$ болог.

$0 < \{x_1 + x_2 + \dots + x_{k+m}\} - \{x_1 + \dots + x_k\} \leq \frac{1}{n+1}$ байх ба эндээс

$$((x_1 + x_2 + \dots + x_{k+m}) - [x_1 + x_2 + \dots + x_{k+m}])$$

$$-((x_1 + x_2 + \dots + x_k) - [x_1 + x_2 + \dots + x_k]) \leq \frac{1}{n+1}$$

$$\Leftrightarrow x_{k+1} + x_{k+2} + \dots + x_{k+m}$$

$$-([x_1 + x_2 + \dots + x_{k+m}] - [x_1 + x_2 + \dots + x_k]) \leq \frac{1}{n+1}$$

$$\Leftrightarrow x_{k+1} + x_{k+2} + \dots + x_{k+m} - N \leq \frac{1}{n+1}$$

болж N бүхэл тоо ба $S = \{x_{k+1}, x_{k+2}, \dots, x_{k+m}\} \subseteq X$ дэд олонлог олдох нь батлагдав. $\triangleleft$

3.4 ММО-47, IX ангийн III даваа

Б.Батцэнгэл

IX-A1 (Б.Батцэнгэл). $1, 2, \dots, 2010, 2011$ тоонуудаас хэдэн тоог сонгон авчээ. Хэрэв сонгогдоогүй үлдсэн тоонууд дотор $x \cdot y = z$ байх ялгаатай x, y, z тоонууд олддоггүй бол хамгийн цөөндөө хэдэн ширхэг тоо сонгон авсан вэ?

IX-A2 (Б.Батцэнгэл). $3^m - 5^n$ ялгавар бүтэн квадрат байх бүх натурал m, n тоонуудыг ол.

IX-A3 (Б.Батцэнгэл). ABC гурвалжинд багтсан I цэгт төвтэй тойрог гурвалжны BC талыг D цэгт шүргэнэ. AI шулуун ABC гурвалжныг багтаасан тойргийг A оройгоос ялгаатай E цэгт огтлох бөгөөд DE шулуун багтаасан тойргийг E цэгээс ялгаатай F цэгт огтолно. $\angle AFI = 90^\circ$ гэдгийг батал.

IX-B1 (Б.Батцэнгэл). a, b, c нь $abc = 1$ байх эерэг тоонууд бол

$$(1 + a^3)(1 + b^3)(1 + c^3) \geq 2 \left(1 + \frac{b}{a} + \frac{c}{b} + \frac{a}{c} \right)$$

тэнцэтгэл биш биелнэ гэдгийг батал.

IX-B2 (Б.Батцэнгэл). Тэгш өнцөгт ABC гурвалжны тэгш өнцгийн оройгоос BH өндөр татав. Гурвалжны BC катет дээр орших D цэгийг AB катетын дундаж M цэгтэй холбосон шулуун CA цацрагийг E цэгээр огтолно. $\angle EBM = \angle BHD$ байхыг батал.

IX-B3 (Б.Батцэнгэл). Натурал n тооны хувьд $(2 + \sqrt{3})^n + (2 - \sqrt{3})^n + 1$ нь анхны тоо бол $n = 3^m$ байх сөрөг биш бүхэл m тоо олдоно гэдгийг батал.

IX-A1: Хариу 43. 2, 3, ..., 43, 44 гэсэн 43 ширхэг тоог сонгон авахад үлдэх тоонууд дотор $x \cdot y = z$ байх ялгаатай 3 тоо олдохгүй. Нөгөө талаас, $(2, 87, 2 \cdot 87 = 174)$
 $(3, 86, 2 \cdot 87 = 174)$

Иймд энэ 2 гурвалжин хоорондоо төсөөтэй. Эндээс $\frac{BF}{DB} = \frac{FE}{IE}$ гэж гарах ба энд $DB = BK$ ба $BE = IE$ гэдгийг тооцвол $\frac{BF}{BK} = \frac{FE}{IE}$ гэж гарна. A, F, B, E цэгүүд нэг тойрог дээр орших тул $\angle FBK = \angle FBA = \angle FEA = \angle FEI$ байна. Энэ нь өмнө нь баталсан тэнцэлтэй хамт FBK, FEI гурвалжнууд хоорондоо төсөөтэй гэдгийг харуулна. Тэгэхлээр $\angle FKA = 180^\circ - \angle FKB = 180^\circ - \angle FIE = \angle FIA$ буюу F, K, I, A цэгүүд нэг тойрог дээр оршино. Иймд $\angle AFI = \angle AKI = 90^\circ$ юм.

IX-B1: $\frac{b}{a} = b^2c, \frac{c}{b} = c^2a, \frac{a}{c} = a^2b$ гэдгийг ашиглан батлах ёстой тэнцэтгэл бишийг

$(1 + a^3)(1 + b^3)(1 + c^3) \geq 2 + 2(b^2c + c^2a + a^2b)$ буюу $a^3b^3 + b^3c^3 + c^3a^3 + a^3 + b^3 + c^3 \geq 2(a^2b + b^2c + c^2a)$ гэж бичиж

болно. Кошийн тэнцэтгэл биш ёсоор

$$a^3b^3 + a^3b^3 + c^3a^3 \geq 3a^3b^2c = 3a^2b$$

$$b^3c^3 + b^3c^3 + a^3b^3 \geq 3b^3c^2a = 3b^2c$$

$c^3a^3 + c^3a^3 + b^3c^3 \geq 3c^3a^2b = 3c^2a$ байх ба эдгээр тэнцэтгэл бишийг хооронд нь нэмбэл

$$a^3b^3 + b^3c^3 + c^3a^3 \geq a^2b + b^2c + c^2a \quad (1) \quad \text{гэж гарна.}$$

Мөн Кошийн тэнцэтгэл биш ёсоор

$$a^3 + a^3 + c^3 \geq 3a^2b$$

$$b^3 + b^3 + c^3 \geq 3b^2c$$

$c^3 + b^3 + c^3 \geq 3c^2a$ байх ба эдгээр тэнцэтгэл бишийг хооронд нь нэмбэл $a^3 + b^3 + c^3 \geq a^2b + b^2c + c^2a$ (2) гэж гарна.

(1) ба (2) тэнцэтгэл бишийг хооронд нь нэмэхэд батлах ёстой тэнцэтгэл биш гарна.

IX-B2: MD шулууны хувьд B оройтой тэгш хэмтэй цэгийг B' гэж тэмдэглэе. M цэг тэгш өнцөгт ABH гурвалжны багтаасан тойргийн төв учраас $MH = MA = MB = MB'$ байна. Тэгэхлээр A, B, B', H цэгүүд нэг тойрог дээр орших бөгөөд $\angle EHB' = \angle AHB' = 180^\circ - \angle ABB' = 180^\circ - \angle MB B'$ юм.

$BB' \perp MD$ бөгөөд $\angle MBD = 90^\circ$ тул $\angle MB B' = \angle MDB = \angle MDB'$ байна. Иймд $\angle EHB' = 180^\circ - \angle MB B' = 180^\circ - \angle MDB' = 180^\circ - \angle EDB'$ буюу E, D, B', H цэгүүд нэг тойрог дээр

оршино. Эндээс

3.5 ММО-47, X ангийн III даваа

Б.Баяржаргал, У.Батзориг

- X-A1 (Б.Баяржаргал). $n, m \geq 2$ натурал тоонууд, p нь анхны тоо бол $p^m - 1 \mid p^n + 1$ байх бүх (n, m, p) гуравтыг ол.
- X-A2 (Б.Баяржаргал). Дурын сөрөг биш x, y, z тоонуудын хувьд $A(x + y + z)^3 \geq x^2y + y^2z + z^2x$ байдаг хамгийн бага A -г ол.
- X-A3 (Б.Баяржаргал). Харгалзан O_1, O_2 төвтэй A цэгээр огтлолцдог ω_1, ω_2 тойргууд өгөгдөв. ω_1, ω_2 -ийг харгалзан B, C -д шүргэх ерөнхий шүргэгч татав. O_3 нь ABC -г багтаасан тойргийн төв ба DO_3 -ийн дундаж цэг нь A байхаар D цэг авав. M нь O_1O_2 -ийн дундаж бол $\angle O_1DM = \angle O_2DA$ гэж батал.
- X-B1 (Б.Баяржаргал). Элементүүдийнх нь нийлбэр 19-т хуваагдаг байх $\{1, 2, \dots, 2011\}$ олонлогийн бүх дэд олонлогийн тоог ол.
- X-B2 (Б.Баяржаргал). $ABCD$ дөрвөн өнцөгтийн AC, BD диагоналиуд O цэгт огтлолцдог ба AC, BD -ийн дундажууд харгалзан M, N бол APD, BPC, OMN гурвалжнуудыг багтаасан тойргийн төвүүд нэг шулуун дээр оршино гэж харуул.
- X-B3 (Б.Баяржаргал). 1-ээс $2n$ хүртлэх натурал тоонууд өгөгджээ. Тэдгээрээс дурын k тоог сонгон авах бүрд нийлбэр нь анхны тоо байх хоёр тоо үргэлж олддог бол k -г сайн тоо гээ. Тэгвэл хамгийн бага сайн тоог ол.
- X-A1: (У.Батзориг) $p^m - 1 \mid p^n + 1 \Rightarrow p^m - 1 \mid p^{2n} - 1 \Leftrightarrow m \mid 2n$.

а) m -сондгой байг. Тэгвэл $m \mid n$ болно. $\Rightarrow n = m \cdot k$ гээ.

Гэтэл $-1 \equiv p^n \equiv (p^m)^k \equiv 1 \pmod{p^m - 1}$

$$\Rightarrow 2 \equiv 0 \pmod{p^m - 1} \Rightarrow \begin{matrix} p^m - 1 = 1 \\ p^m - 1 = 2 \end{matrix}$$

$$\Rightarrow \begin{matrix} p = 2, m = 1 \\ p = 3, m = 1 \end{matrix} \Rightarrow (n, 1, 2); (n, 1, 3)$$

б) m — тэгш байг. Өөрөөр хэлбэл $m = 2k$ бол $k|n \Rightarrow$
 $-1 \equiv p^n \equiv (p^k)^s \equiv 1 \pmod{p^k - 1}$
 $\Rightarrow 2 \equiv 0 \pmod{p^k - 1} \Rightarrow \begin{matrix} p^k - 1 = 2 \Rightarrow k = 1, p = 3 \\ p^k - 1 = 1 \Rightarrow k = 1, p = 2 \end{matrix}$
 $k = 1$ ба $p = 3$ үед $8|3^n + 1$ жишлэг шийдгүй. Харин
 $k = 1$ ба $p = 2$ үед $m = 2$ ба энэ үед $2^2 - 1|2^n + 1 \Rightarrow 3|2^n + 1$
 $\Rightarrow n$ — сондгой тоо.
 $m, n \geq 2$ тул хариу: $(n, 2, 2)$; n — сондгой тоо.

X-A2: Өгсөн тэнцэтгэл биш нэгэн төрлийн тэнцэтгэл биш тул
 $x + y + z = 1$ гэж үзэж болно. Мөн өгсөн тэнцэтгэл биш цикл
учраас $x = \max(x, y, z)$ гэж үзэж болно.

а) $x \geq y \geq z$ байг. $x^2y + y^2z + z^2x \leq x^2y + y^2z + z^2x$
 $+ z[xy + (x - y)(y - z)]$
 $= (x + z)^2 \cdot y = 4 \left(\frac{1}{2} - \frac{1}{2}y \right) \left(\frac{1}{2} - \frac{1}{2}y \right) \leq \frac{4}{27}.$

б) $x \geq z \geq y$ байг. $x^2y + y^2z + z^2x \leq x^2z + z^2y + y^2z$
 $- (x - z)(z - y)(x - y) \leq x^2z + z^2y + y^2x \leq \frac{4}{27}.$

Хамгийн сүүлийн тэнцэтгэл биш нь эрэмбэтэй тул а)-ёсоор
үнэлнэ. Тэнцэтгэл биш $\left(\frac{2}{3}, \frac{1}{3}, 0 \right)$ үед тэнцэлдээ хүрнэ.

X-A3: 46-р олимпиадын 4-ын давааг үз.

X-B1: $f(x) = (1 + x)(1 + x^2) \dots (1 + x^{2011})$
 $= a_0 + a_1x + a_2x^2 + \dots + a_kx^k$ олон гишүүнтийг авч үзье.
 $\varepsilon \in U'_{19}$ ба $19 \nmid k$ байг.
 $\Rightarrow \varepsilon^{18} + \varepsilon^{17} + \dots + \varepsilon^2 + \varepsilon + 1 = 0$
 $\varepsilon^{18k} + \varepsilon^{17k} + \dots + \varepsilon^{2k} + \varepsilon^k + 1 = 0$
 $f(1) + f(\varepsilon) + \dots + f(\varepsilon^{18}) = 19a_0 + a_1(1 + \varepsilon + \varepsilon^2 + \dots + \varepsilon^{18})$
 $+ a_2(1 + \varepsilon^2 + \dots + \varepsilon^{36}) + \dots + a_{19} \underbrace{(1 + 1 + \dots + 1)}_{19} + \dots$ Тэгвэл бидний

олох ёстой нийт 19-д хуваагддаг олонлогийн тоо нь:

$\Rightarrow a_0 + a_{19} + a_{38} + \dots = \frac{1}{19}(f(1) + f(\varepsilon) + \dots + f(\varepsilon^{18}))$ болно.

$f(1) = 2^{2011}$, $f(\varepsilon^k)$ – үүдийг ММО-46, х.98-г анхааран бод.

X-B2: AOD -г багтаасан тойргийн төвийг O_1

BOC -г багтаасан тойргийн төвийг O_2

COD -г багтаасан тойргийн төвийг O_3

BOA -г багтаасан тойргийн төвийг O_4 гэе. Тэгвэл $O_1O_2O_3O_4$ дөрвөн өнцөгт нь параллелограмм ба уг //–граммын диагналаудын огтлолцлын цэг дээр MON гурвалжинг багтаасан тойргийн төв нь оршино гэдгийг харахад төвөггүй тул та бүхэнд үлдээе. **X-B3:** Лемм. $\{1, 2, \dots, 2n\}$

олонлогийг $A = \{a_1, \dots, a_n\}$; $B = \{b_1, \dots, b_n\}$ ба

$1 \leq i \leq n$, $a_i + b_i$ анхны тоо байхаар хувааж болно.

▲ Бертранны постулятаар $\exists p \in \mathbb{P}$, $2n < p < 4n$ байна. $p = 2n + m$ байг. Тэгвэл m сондгой болно.

Индукцийн өмнөх алхмаар $\{1, 2, \dots, m - 1\}$ олонлогийг бодлогын нөхцөл хангахаар хувааж чадна.

Харин $m, m + 1, \dots, 2n$ олонлогийг $\{2n, m\}$, $\{m + 1, 2n - 1\}, \dots$ гэж хуваахад Лемм батлагдана. Эндээс $\min(k) = n + 1$ болно.

3.6 ММО-47, XI ангийн III даваа

Б. Батбаясгалан

XI-A1 (Б.Батбаясгалан). P нь 2011 ширхэг ялгаатай бодит язгууртай 2011 зэргийн олон гишүүнт байг. Хамгийн олондоо хичнээн коэффициент нь 0-тэй тэнцүү байж болох вэ?

XI-A2 (Б.Батбаясгалан). ABC гурвалжны AB ба BC талууд дээр харгалзан D ба E цэгүүдийг авав. DE хэрчмийг $K_1, K_2, \dots, K_{2n}$ цэгүүд $2n+1$ ширхэг ижил урттай хэрчмүүдэд хуваадаг байг ($DK_1 = K_1K_2 = K_2K_3 = \dots = K_{2n-1}K_{2n} = K_{2n}E$). Хэрэв BK_n цацраг AC талыг T_n цэгт, BK_{n+1} цацраг AC талыг T_{n+1} цэгт огтолдог бол $T_n T_{n+1} \leq \frac{AC}{2n+1}$ гэж батал.

XI-A3 (Б.Батбаясгалан). $\mathcal{H} = A_1 A_2 \dots A_n$ гүдгэр олон өнцөгт өгөгдөв. Хэрэв $A_{i-1} A_{i+1}$ ($A_{n+1} = A_1, A_0 = A_n$) хэрчмийн дундаж цэгийн хувьд A_i оройтой тэгш хэмтэй цэг A'_i нь $\mathcal{H}$ дотор (хүрээн дээр байж болно) байдаг бол A_i -г сайн орой гээ. $\mathcal{H}$ -д дор хаяж $n-3$ ширхэг сайн орой бий гэж батал.

XI-B1 (Б.Батбаясгалан). ABC гурвалжны ортоцентр нь H , BC талын дундаж цэг D байг. H -г дайрсан шулуун AB , AC талуудыг харгалзан F , E цэгүүдэд $AE = AF$ байхаар огтолдог. DH цацраг ABC гурвалжныг багтаасан тойргийг P цэгт огтолдог бол P , A , E , F цэгүүд нэг тойрог дээр оршино гэж батал.

XI-B2 (Б.Батбаясгалан). x, y, z нь $x + y + z \geq 6$ байх эерэг бодит тоонууд байг.

$$x^2 + y^2 + z^2 + \frac{x}{y^2 + z + 1} + \frac{y}{z^2 + x + 1} + \frac{z}{x^2 + y + 1}$$

илэрхийллийн хамгийн бага утыг ол.

XI-B3 (Б.Батбаясгалан). $p > 3$ анхны тоо байг.

$$\sum_{i=1}^p C_{i,p}^p \cdot C_{(p-i+1)p}^p$$


тоог p^3 -д хуваахад гарах үлдэгдлийг ол.

XI-A1: Ямарч олон гишүүнтийн ялгаатай 2 язгуурын хооронд уламжлалынх нь ядаж нэг язгуур оршдог. Үүнийг ашиглан анхны олон гишүүнтийн аль ч эрэмбийн уламжлал нь давхар язгуургүй гэдгийг хялбар харуулж болно. Анхны олон гишүүнтэд дараалсан 2 тэг коэффициентбайж болохгүй гэдгийг харуулъя. Хэрэв дараалсан 2 тэг коэффициент байвал түүний аль нэг эрэмбийн уламжлал нь x^2 -д хуваагдахад хүрнэ. Иймд анхны олон гишүүнтэд дараалсан 2 тэг коэффициент байхгүй. Иймд хамгийн ихдээ $2012/2 = 1006$ ширхэг л тэг коэффициент байж болох нь ээ. Ийм олон гишүүнт байна гэдгийг харуулъя.

$$P(x) = x(x^2 - 1^2)(x^2 - 2^2) \dots (x^2 - 1005^2)$$

олон гишүүнт нь ялгаатай язгууруудтай бөгөөд сондгой функц тул бүх тэгш зэргийн өмнөх коэффициентүүд нь тэг байна.

XI-A2: $\triangle BDK_1, \triangle BK_1K_2, \triangle BK_2K_3, \dots, \triangle BK_{2n}E$ гурвалжуудын талбай хоорондоо тэнцүү тул тэдгээрийг S гээ.



Мөн $\triangle BAT_1$ -ийн талбайг S_1 , $\triangle BT_1T_2$ -ийн талбайг S_2 , $\triangle BT_{2n}C$ -ийн талбайг S_{2n+1} гээ.

$$\begin{aligned} \mu_n &= \frac{S_1 + S_2 + \dots + S_{2n+1}}{(2n+1)S}; \mu_{n-1} = \frac{S_2 + S_3 + \dots + S_{2n}}{(2n-1)S}; \\ \mu_{n-2} &= \frac{S_3 + S_4 + \dots + S_{2n-1}}{(2n-3)S}; \mu_k = \frac{S_{n+1-k} + \dots + S_{n+1+k}}{(2k+1)S}; \\ \mu_1 &= \frac{S_n + S_{n+1} + S_{n+2}}{3S}; \mu_0 = \frac{S_{n+1}}{S} \end{aligned}$$

байг. Тэгвэл

$$\frac{AC}{2n+1} = \frac{S_{ABC}}{h(2n+1)} = \frac{S_1 + S_2 + \dots + S_{2n+1}}{(2n+1)h} = \mu_n \frac{S}{n}$$

$T_n T_{n+1} = \frac{S_{n+1}}{h} = \mu_0 \frac{S}{h}$ болно. $\mu_n \geq \mu_0$ гэж баталвал бодлого бодогдоно. Одоо $\mu_n \geq \mu_{n-1}$ гэж харуулъя.

$$S_1 + S_{2n+1} \geq 2\sqrt{S_1 \cdot S_{2n+1}} \quad \text{учир}$$

$$\mu_n = \frac{S_1 + S_2 + \dots + S_{2n+1}}{(2n+1)S} \geq \frac{S_2 + S_3 + \dots + S_{2n} + 2\sqrt{S_1 S_{2n+1}}}{(2n+1)S}$$

$$(2n+1)\mu_n \geq \frac{S_2 + \dots + S_n}{S} + 2\sqrt{\frac{S_1 S_{2n+1}}{S^2}}$$

$$= (2n-1)\mu_{n-1} + 2\sqrt{\frac{S_1 S_{2n+1}}{S^2}} \quad (*)$$

$$\frac{S_1}{S} = \frac{AB \cdot BT_1}{BD \cdot BK_1}, \quad \frac{S_{2n+1}}{S} = \frac{BC \cdot BT_{2n}}{BE \cdot BK_{2n}}, \quad \frac{BT_1 \cdot BT_{2n}}{BK_1 \cdot BK_{2n}}$$

$$= \frac{S_{\Delta BT_1 T_{2n}}}{S_{\Delta BK_1 K_{2n}}} = \frac{S_2 + \dots + S_{2n}}{(2n-1)S} = \mu_{n-1}$$

$$\frac{AB \cdot BC}{BD \cdot BE} = \frac{S_{ABC}}{S_{BDE}} = \frac{S_1 + S_2 + \dots + S_{2n+1}}{(2n+1)S} = \mu_n$$

гэдгийг тооцвол

$$\frac{S_1 S_{2n+1}}{S^2} = \frac{AB \cdot BT_1}{BD \cdot BK_1} \cdot \frac{BC \cdot BT_{2n}}{BE \cdot BK_{2n}} = \mu_{n-1} \cdot \mu_n.$$

Иймд (*) тэнцэтгэл биш нь $((2n+1)\mu_n - (2n-1)\mu_{n-1})^2 \geq 4\mu_1\mu_2$ болно. Энэ тэнцэтгэл бишийг μ_{n-1}^2 -д хуваагаад $\frac{\mu_n}{\mu_{n-1}} = \lambda$ гэвэл $(2n+1)^2\lambda^2 - 2(4n^2+1)\lambda + (2n-1)^2 \geq 0$ болно.

$$\lambda_{1,2} = \frac{4n^2+1 \pm 4n}{(2n+1)^2}, \quad \lambda_1 = \left(\frac{2n-1}{2n+1}\right)^2, \quad \lambda_2 = 1$$

$$\lambda \leq \left(\frac{2n-1}{2n+1} \right)^2 \text{ эсвэл } \lambda \geq 1$$


$$\lambda \leq \left(\frac{2n-1}{2n+1} \right)^2 \text{ бол } \frac{(S_1 + S_2 + \dots + S_{2n+1})(2n-1)}{(2n+1)(S_2 + \dots + S_{2n})} \leq \left(\frac{2n-1}{2n+1} \right)^2$$

$$(2n+1)(S_1 + \dots + S_{2n+1}) + 2(S_2 + S_3 + \dots + S_{2n}) < 0$$

болж зөрчилд хүрнэ. Иймд $\lambda \geq 1$ буюу $\mu_n \geq \mu_{n-1}$. Одоо энэ үйлдлийг μ_n -ийн оронд μ_{n-1} ээр солин үргэлжлүүлвэл



$\mu_{n-1} \geq \mu_{n-2}$ болох ба үүнийг үргэлжлүүлвэл $\mu_n \geq \mu_{n-1} \geq \dots \geq \mu_0$ болж батлагдана. Тэнцэтгэл биш $DE \parallel AC$ үед тэнцэлдээ хүрнэ.

XI-A3: Индукцээр баталъя. 4 өнцөгт маань трапец үед илэрхий. Трапец биш үед зураг 1-т үзүүлсэн A орой сайн орой болох нь илэрхий.



Зураг 1,

Одоо $n > 4$ үед баталъя. Хэрэв гүдгэр олон өнцөгтийн аль нэг орой нь муу бол түүнийг аль ч диагональн дундач цэгийн хувьд тэгш хэмтэй хувиргахад гарах цэг олон өнцөгтийн гадна байна гэдгийг баталъя. Зураг 2-т үзүүлсэнээр A нь сайн орой биш бөгөөд BC диагональн дундач цэгийн хувьд тэгш хэмтэй цэг D нь олон өнцөгт дотор оршдоггүй гэе.




Зураг 2,

E нь B -тэй хөрш орой байг. E орой нь l_2 шулууны баруун талд зураг 2а)-д үзүүлсэнээр байрлах бол BCF гурвалжин дотор D орших тул F цэг олон өнцөгт дотор орших боломжгүй. Эсрэг тохиолдолд D цэг олон өнцөгт дотор ороход хүрнэ. Хэрэв E орой нь зураг 2а)-д F цэгийн орших мужид орших бол BCE гурвалжин дотор D орших тул зөрчил үүснэ.

Хэрвээ E нь зураг 2b)-д үзүүлсэнээр l_2 -ийн зүүн талд оршдог бол A ба F цэгүүд BE талын 2 талд орших тул F нь олон өнцөгт дотор оршихгүй. Ийм аргаар бид сайн биш оройг бүх диагоналийн дундачийн хувьд тэгш хэмтэй хувиргахад гарах цэгүүд бүгд олон өнцөгтийн гадна оршино гэдгийг баталж чадна. Хэрвээ E нь зураг 2b)-д үзүүлсэнээр l_2 -ийн зүүн талд оршдог бол A ба F цэгүүд BE талын 2 талд орших тул F нь олон өнцөгт дотор оршихгүй. Ийм аргаар бид сайн биш оройг бүх диагоналийн дундачийн хувьд тэгш хэмтэй хувиргахад гарах цэгүүд бүгд олон өнцөгтийн гадна оршино гэдгийг баталж чадна. Одоо бодлогоо бодъё. Хэрэв уг олон өнцөгтөд 4 ширхэг сайн биш орой байдаг бол тэдгээрээр үүсэх дөрвөн өнцөгт нь дээрх өгүүлбэр ёсоор 4 ширхэг муу оройтой олон өнцөгт болоход хүрч зөрчил үүсэв. Бодлого бодогдов.

XI-B1:



$\angle BHC = \angle BQC$ ба $BD = DC$ учир HD ба DQ нь медианууд

болох ба $\angle HDB = \angle CDQ$ учир $HD = DQ$ болох нь хялбар мөрдөнө. Иймд $BQCH$ нь $//$ грам болно. $\angle ABH = \angle ACH$ учир $\triangle CEH \sim \triangle BFH \Rightarrow \frac{BF}{CE} = \frac{BH}{CH} = \frac{CQ}{BQ}$. (*)

Мөн $BQCH //$ грамм гэдгээс $S_{PBQ} = S_{PQC}$,

$$PB \cdot BQ \cdot \sin \angle PBQ = PC \cdot CQ \cdot \sin \angle QCP,$$

$$\angle PBQ + \angle QCP = 180^\circ \text{ учир } PB \cdot BQ = PC \cdot CQ, \quad \frac{CQ}{BQ} = \frac{PB}{PC}.$$

$$(*)\text{-оос } \frac{BF}{CE} = \frac{PB}{PC} \text{ буюу } \frac{BF}{PB} = \frac{CE}{PC}$$

$$\angle PBA = \angle PCA \Rightarrow \triangle PBF \sim \triangle PCE \Rightarrow$$

$$\angle PFB = \angle PEC, \angle PFA = \angle PEA$$

тул $PAEF$, 4 өнцөгт тойрогт багтана.

XI-B2: Коши-Буняковскийн тэнцэтгэл бишээр

$$\frac{a_1^2}{b_1} + \frac{a_2^2}{b_2} + \frac{a_3^2}{b_3} \geq \frac{(a_1 + a_2 + a_3)^2}{b_1 + b_2 + b_3}$$

байна. Үүнийг ашиглавал

$$\begin{aligned} A &= \sum_{cyc} \frac{x}{y^2 + z + 1} = \sum_{cyc} \frac{x^2}{x(y^2 + z + 1)} \\ &\geq \sum_{cyc} \frac{(x + y + z)^2}{\sum_{cyc} xy^2 + \sum_{cyc} xy + \sum_{cyc} x} = B \end{aligned}$$

$x + y + z > 6$ гэдгийг тооцвол

$$\begin{aligned} B &\geq \frac{6(x + y + z)}{\sum_{cyc} xy^2 + 1/6 \cdot \sum_{cyc} x \sum_{cyc} xy + 1/36 \cdot (\sum_{cyc} x)^3} \\ &= \frac{216(x + y + z)}{36 \sum_{cyc} xy^2 + 6 \cdot \sum_{cyc} x \sum_{cyc} xy + (\sum_{cyc} x)^3} = 216C \end{aligned}$$

Одоо $C \geq \frac{1}{21(x^2 + y^2 + z^2)}$ (*) гэж баталъя. Үнэндээ

$$(*) \Leftrightarrow 21(1 + y + z)(x^2 + y^2 + z^2) \geq 36(xy^2 + yz^2 + zx^2) \\ + 6(x + y + z)(xy + yz + zx) + (x + y + z)^3.$$

Үүнийг задлаад эмхтгэвэл

$$20(x^3 + y^3 + z^3) + 12(xz^2 + yx^2 + zy^2) \\ > 24(xy^2 + yz^2 + zx^2) + 24xyz. \quad (**)$$

Энэ нь дараах 2 тэнцэтгэл бишийн нийлбэр юм.

$$12[x(x - z)^2 + y(y - x)^2 + z(z - y)^2] \geq 0$$

$$8(x^3 + y^3 + z^3) \geq 24xyz$$

$x^2 + y^2 + z^2 = t$ гэвэл

$$x^2 + y^2 + z^2 + \frac{x}{y^2 + z + 1} + \frac{y}{z^2 + x + 1} + \frac{z}{x^2 + y + 1} \\ \geq x^2 + y^2 + z^2 + \frac{216}{21(x^2 + y^2 + z^2)} = t + \frac{216}{21t} = f(t) \quad (***)$$

болно. Нөгөө талаас

$x + y + z \geq 6$ тул $x^2 + y^2 + z^2 \geq \frac{(x + y + z)^2}{3} \geq 12$ байна. $t \geq 12$ үед $f(t)$ -ийн хамгийн бага утга нь $f(12)$ байна. (***) тэнцэтгэл биш нь $x = y = z = 2$ үед тэнцэлдээ хүрэх тул $\min A = f(12) = 12 + \frac{216}{21 \cdot 12} = 12\frac{6}{7}$ байна.

XI-B3: $p > 3$ анхны тоо үед

$$A = \sum_{k=1}^{p-1} \frac{1}{k} = \frac{1}{2} \sum_{k=1}^{p-1} \left(\frac{1}{k} + \frac{1}{p-k} \right) = \frac{p}{2} \sum_{k=1}^{p-1} \frac{1}{k(p-k)} \equiv 0 \pmod{p}$$

$$B = \sum_{1 \leq k < l \leq p-1} \frac{1}{k \cdot l} = \frac{1}{2} \left[\left(\sum_{k=1}^{p-1} \frac{1}{k} \right)^2 - \sum_{k=1}^{p-1} \frac{1}{k^2} \right] \equiv \frac{1}{2} \left[A^2 - \sum_{k=1}^{p-1} k^2 \right]$$

$$= \frac{1}{2} \left[A^2 - \frac{(p-1)p(2p-1)}{6} \right] \equiv 0 \pmod{p}$$

$$\begin{aligned} C &= \sum_{i=1}^p i(p-i+1) = \frac{p^2(p+1)}{2} - \frac{p(p+1)(2p+1)}{6} + \frac{p(p+1)}{2} \\ &= \frac{p(p+1)(p+2)}{6} \equiv \frac{p^2}{2} + \frac{p}{3} \pmod{p^3} \end{aligned}$$

байна.

$$\begin{aligned} C_{i,p}^p &= \frac{pi(pi-1)\dots(pi-p+1)}{p!} \\ &\equiv \frac{(-1)^{p-1}i}{(p-1)!} \left[(p-1)! - \sum_{k=1}^{p-1} \frac{(p-1)!}{k} \cdot (pi) + \sum_{1 \leq k < l \leq p-1} \frac{(p-1)!}{k \cdot l} \cdot (pi)^2 \right] \\ &\equiv (-1)^{p-1}i[1 - A \cdot (pi) + B \cdot (pi)^2] \equiv (-1)^{p-1}i[1 - A \cdot (pi)] \pmod{p^3} \end{aligned}$$

тул

$$\begin{aligned} \sum_{i=1}^p C_{i,p}^p \cdot C_{(p-i+1)p}^p &\equiv \sum_{i=1}^p i(p-i+1)[1 - A \cdot (pi) - A \cdot (p(p-i+1))] \\ &\equiv [1 - A(p^2 + p)]C \equiv C \equiv \frac{p^2}{2} + \frac{p}{3} \pmod{p^3}. \end{aligned}$$

3.7 ММО-47, Багын багшийн III даваа

Д.Ганзориг

ББ-А1 (Д.Ганзориг). Зөв 2011 өнцөгтийн 52 оройг нь улаан өнгөөр бусадыг нь цэнхэр өнгөөр будав. Ижил өнгийн оройтой адил хажуут гурвалжны тоо нь будалтаас үл хамаарна гэж батал.

ББ-А2 (Д.Ганзориг). Нэмэгдэхүүн бүр нь бүхэл тооны 2000 зэрэгт болох 2001 ширхэг тооны нийлбэрт дор хаяж 100 янзаар бичигдэх бүхэл тоонууд оршин байна гэж батал.

ББ-А3 (Д.Ганзориг). Сум 1600 малчинтай ба тус бүр 97 хүнтэй 36 хоршоо байгуулав. Дор хаяж 4 ерөнхий гишүүнтэй хоёр хоршоо олдоно гэж батал.

ББ-В1 (Д.Ганзориг). Тойрог дээр 2011 ширхэг тоо бичсэн байв. Хэрэв ямар нэг дараалсан x, y, z, t -тоонуудын хувьд $(x-t)(y-z) < 0$ бол y, z -ийн байрыг солих үйлдэл төгсгөлөг алхамын дараа зогсох уу?

ББ-В2 (Д.Ганзориг). $\underbrace{\sqrt{99 \dots 99}}_{4020}$ тооны аравтын бичлэгийн тасла-
лаас хойшхи 2011-р цифрийг ол.

ББ-В3 (Д.Ганзориг). 5 нэгж талбайтай квадратад нэгж талбайтай 9 ширхэг гүдгэр олон өнцөгт байрлуулав. Ерөнхий талбай нь $\frac{1}{9}$ өөс багагүй хоёр олон өнцөгт олдоно гэж үзүүл.

ББ-А1: (Ч.Сугардорж) 52-улаан, 959-цэнхэр байгаа. 2 өнгө хоёулаа орсон байх адил хажуут гурвалжны тоог тоолъё. Өөр өнгийн дурын 2 цэгийг авахад уг 2 цэг суурийн цэгүүд нь болох адил хажуут гурвалжин 1 ширхэг, уг 2 цэг хажуу тал нь болох гурвалжин 2 ширхэг буюу уг 2 цэгийг агуулсан адил хажуут гурвалжин 3 ширхэг байна. 1 улаан ($A(y)$), 1 хөх ($B(x)$) цэгийг сонгох боломжийн тоо $52 \cdot 1959$ болох ба адил хажуут $A(y)B(x)C(z)$ гурвалжин 2 янзаар тоологдох

($A(y)B(x)$ талыг yx тал гэвэл $\Delta A(y)B(x)C(z)$ – д z ямарч өнгөтэй байсан yx хэлбэрийн яг 2 тал байгаа) тул тийм $\frac{52 \cdot 1959 \cdot 3}{2}$ ширхэг гурвалжин 2 өнгийг агуулсан адил хажуут байна. Иймд 2 өнгө хоёулаа оролцсон адил хажуут гурвалжны тоо будалтаасаа үл хамааран тогтмол байгаа тул бүх орой нь адил байх адил хажуут гурвалжны тоо будалтаас хамаарахгүй: Нийт адил хажуут гурвалжны тоо дурын 2 цэгийг сонгоход уг 2 цэгээр суурь хийсэн адил хажуут гурвалжин цор ганц тул C_{2011}^2 байна.

ББ-А2: (Ч.Сугардорж) $s = 2000$, $m = 2001$, $t = 100$ гэе. $n \geq 2^n \cdot m! \cdot m \cdot t$ байх n тоог сонгоё.

$1 \leq a_1 \leq \dots \leq a_m \leq n$ байх ($a_1, \dots, a_m$) m -тыг сонгох боломжийн тоо нь $1 \leq a_1 < \dots < a_m \leq n$ байхаар ($a_1, \dots, a_m$) m -тыг сонгох боломжийн тооноос их. Энэ сүүлчийн сонголтын боломж нь C_n^m . Сонголт бүр дэх $a_1^s + \dots + a_m^s = A \leq n^s \cdot m$ ба ($a_1, \dots, a_m$)-ийг A -дугаартай хайрцагт хийе. Хайрцагны тоо $n^s \cdot m$ -ээс хэтрэхгүй тул Дирихлейн зарчмаар дор хаяж $C_n^m / n^s \cdot m$ ширхэг m -тыг агуулсан хайрцаг олдоно. Гэтэл

$$\begin{aligned} C_n^m &= \frac{n(n-1)\dots(n-m+1)}{m!} > \frac{(n/2)^m}{m!} = \frac{n^m}{2^m \cdot m!} = \frac{n \cdot n^{m-1}}{2^m \cdot m!} \\ &\geq \frac{2^m \cdot m! \cdot m \cdot t \cdot n^{m-1}}{2^m \cdot m!} = t \cdot m \cdot n^{m-1} = t \cdot n^s \cdot m \end{aligned}$$

буюу $\frac{C_n^m}{n^s \cdot m} > t = 100$.


ББ-А3: $\uparrow A_i - i$ -р хоршоо, $i = 1, 36$, V сумын малчид гэе. Эсэргээс нь аль ч 2 хоршоо 3-аас илүүгүй ерөнхий гишүүнтэй $|A_i A_j| \leq 3$ гэе.

$$|V| = 1600 \geq \left| \bigcup_{i=1}^{36} A_i \right| \geq \text{ММК I, 5.9.15 б)}\text{-ээр}$$

$$\sum |A_i| - \sum |A_i A_j| \geq 36 \cdot 97 - C_{36}^2 \cdot 3 = 1602$$

зөрчил үүсгэв.

ББ-В1:



байг. $x_1x_2 + \dots + x_nx_1$ (*) - нийлбэрийг авч үзье.

x_i, x_{i+1} ($i + 1 = 1$)-үүдийн байрыг солиход (*)-нийлбэр ихсэнэ гэж үзүүл. Нөгөө талаас $x_1, \dots, x_n$ -тоонуудыг тойрог дээгүүр байрыг нь солих боломжийн тоо төгсгөлөг. Иймд дээрхи үйлдэл зогсоно.

ББ-В2:

$$A = \underbrace{\sqrt{9 \dots 9}}_{2n} = \sqrt{10^{2n} - 1}; \quad r_n = 10^n - A = \frac{10^{2n} - A^2}{10^n + A} = \frac{1}{10^n + A}$$

$$A < 10^n \Rightarrow r_n > \frac{1}{2 \cdot 10^n}; \quad A = 10^n - r_n < 10^n - \frac{1}{2 \cdot 10^n} = \underbrace{9 \dots 9}_n, \underbrace{9 \dots 9}_n 5.$$

Нөгөө талаас

$$\frac{1}{10^n + A} < \frac{3}{5 \cdot 10^n} \Leftrightarrow 2 \cdot 10^n < 3A \Leftrightarrow 4 \cdot 10^{2n} < 9A^2 = 9(10^{2n} - 1) = 0$$

$$\Rightarrow r_n < \frac{3}{5 \cdot 10^n}$$

$$\text{болно. Иймд } A = 10^n - r_n > 10^n - \frac{3}{5 \cdot 10^n} = \underbrace{9 \dots 9}_n, \underbrace{9 \dots 9}_n 4. \text{ Эндээс}$$

$$\underbrace{9 \dots 9}_n, \underbrace{9 \dots 9}_n 4 < A \underbrace{9 \dots 9}_n, \underbrace{9 \dots 9}_n 5. \text{ Иймд 4 болно.}$$

ББ-В3: Бодлого хавтгай дээр n - дүрс өгсөн.

$i_1, \dots, i_k$ -дугаартай дүрсүүдийн огтлолцол $S_{i_1 \dots i_k}$ байг. S -нь бүрхэгдсэн дүрсийн талбай. M_k -нь бүх $S_{i_1 \dots i_k}$ -үүдийн нийлбэр бол m -тэгш үед $S \geq M_1 - M_2 + M_3 - \dots + (-1)^{m+1} M_m$,

m -сондгой үед $S \leq M_1 - M_2 + M_3 - \dots + (-1)^{m+1} M_m$ байна.

(ММК-I Дирихлейн зарчим).

$$5 \geq 9 - M_2 \Rightarrow M_2 \geq 4. \text{ 9-олон өнцөгтөөс нийт } C_9^2 = 36 \text{ хос үүсгэж}$$

$$\text{болох тул эдгээрийн ямар нэг хоёрын еранхий талбай нь } \frac{M_2}{36} \geq \frac{1}{9} \text{ байна.}$$

3.8 ММО-47, Дундын багшийн III даваа

Б.Ганбилэг, Ц.Дашдорж

ДБ-А1 (Ц.Дашдорж). 2^n ялгаатай тоо бүхий

$a_1, a_2, a_3, a_4, \dots, a_{2^n-1}, a_{2^n}$ дарааллаас

$$a_{2^{n-1}+1}, a_1, a_{2^{n-1}+2}, a_2, \dots, a_{2^n}, a_{2^{n-1}}$$

дараалалд шилжих f үйлдэл зөвшөөрөгджээ. f үйлдлийг хамгийн цөөндөө хэдэн удаа гүйцэтгэхэд анхны дараалал гарах вэ?

ДБ-А2 (Ц.Дашдорж). $p \in \mathbb{P}$, $a \in \mathbb{Z}$, $d \mid n$ байг. $p \mid \Phi_n(a)$, $\Phi_d(a)$ бол $n = d \cdot p^\alpha$ ба $p^2 \nmid \Phi_n(a)$ гэж батал, энд $\Phi_n(x)$ нь n дугаар дугуй олон гишүүнт.

ДБ-А3 (Ц.Дашдорж). $A \subseteq \mathbb{N}$, $|A| = \infty$ ба $\forall a \in A$ -ийн хувьд

$$a^n + a^{n-1} + \dots + a + 1 \mid a^{n!} + a^{(n-1)!} + \dots + a^{1!} + 1$$

байх бүх $n \in \mathbb{N}$ -г ол.

ДБ-В1 (Ц.Дашдорж). $\sum_k \binom{n}{k} \binom{n-k}{\lfloor \frac{n-k}{2} \rfloor} 2^k = \binom{2n+1}{n}$ болохыг батал.

ДБ-В2 (Ц.Дашдорж). $3 \mid 2^n - 1$ ба $\exists m$, $\frac{2^n - 1}{3} \mid 4m^2 + 1$ байх бүх $n \in \mathbb{N}$ -г ол.

ДБ-В3 (Ц.Дашдорж). $M = \{(x_i, y_i) \mid i = 1, 2p-1\} \subseteq \mathbb{Z}_p^2$, $|M| = 2p-1$ ба $\mathbb{Z}_p$ -ийн элемент бүр нь $x_1, \dots, x_{2p-1}$ дараалалд 2-оос илүүгүй удаа ордог байг. Тэгвэл M нь p гишүүнтэй тэг дэд дараалал ($|I| = p$, $I \subseteq \{1, 2, \dots, 2p-1\}$ ба $\sum_{i \in I} (x_i, y_i) = (\sum_{i \in I} x_i, \sum_{i \in I} y_i) = (0, 0) \in \mathbb{Z}_p^2$) агуулна гэж батал.

ДБ-А1: f буулгалтаар дарааллын m -р гишүүн k -р байранд ирдэг бол $f(m) = k$; анх өгөгдсөн дараалал гарах f буулгалтын

хамгийн бага тоог f_n гэж тэмдэглэе. $s \in \mathbb{N}$ $s \leq 2^{n-1}$ байг.
 $f(s) = 2s$; $f(2^{n-1} + s) = 2s - 1$ болно.
 $2(2^{n-1} + s) \equiv 2s - 1 \pmod{2^n + 1}$ тул $m \in \mathbb{N}$,
 $m = \overline{1, 2^n}$ үед $f(m) = 2m \pmod{2^n + 1}$

$$f^2(m) = f(f(m)) \equiv 2^2 \cdot m \pmod{2^n + 1}, \dots, f^{2^n}(m) \equiv 2^{2^n} \cdot m \pmod{2^n + 1}$$

ба $2^{2^n} \equiv 1 \pmod{2^n + 1}$ тул $f^{2^n}(m) \equiv m \pmod{2^n + 1}$. Энэ нь $2n$ удаа үйлдэл хийхэд дарааллын аль ч гишүүн анхны байрандаа ирнэ гэсэн үг. $f_n \geq 2n$ гэж батлавал $f_n = 2n$ болно. Дарааллын эхний гишүүн $2n$ -ээс цөөн үйлдлээр байрандаа ирж чадахгүй буюу $m = 1$ үед $q \in \{1, 2, 3, \dots, 2n - 1\}$ бүрийн хувьд $2^q \not\equiv 1 \pmod{2^n + 1}$ гэж батлахад хангалттай. $2^\delta \equiv 1 \pmod{2^n + 1}$ энд δ нь хамгийн бага илтгэгч гэвэл $2^\delta - 1 > 2^n + 1$ $\delta > n$ ба $2^{2^n} \equiv 1 \pmod{2^n + 1}$ тул $\delta | 2n$ болно. $\delta = 2n$ болох тул батлагдав.

ДБ-А2: $n = d \cdot p^\alpha$ болох нь ММК II, 10.6, Өгүүлбэр 1б) ба бодлого 10.9б). 1б)-ээс гарна.

$d \cdot p^{\alpha-1} = d_s$ гэе. $a^d \equiv 1(p) \Rightarrow a^{d_s} \equiv 1(p)$. $\Phi_n(a) | \frac{a^n - 1}{a^{d_s} - 1}$ тул $p^2 \nmid \frac{a^n - 1}{a^{d_s} - 1}$ гэж харуулахад $p^2 \nmid \Phi_n(a)$ гэж гарна. $a^{d_s} = B$ гэе. $B \equiv 1(p)$, $B = pk + 1$, $k \in \mathbb{N}$ гэвэл $B - 1 = pk$ болно. $p > 2$ байг

$$\frac{a^n - 1}{a^{d_s} - 1} = \frac{B^p - 1}{B - 1} = \frac{(pk + 1)^p - 1}{pk}$$

$$= p + \frac{p(p-1)}{2} \cdot kp + (kp)^2(\dots) \equiv p \pmod{p^2}.$$

$p = 2$ үед a -сондгой. $4 | n$ үед $a^n - 1 = (a^{n/2} - 1)(a^{n/2} + 1)$. ММК II, 10.6. Дасгал 2-оос $\Phi_n(a) | \frac{a^n - 1}{a^{n/2} - 1} = a^{n/2} + 1$. $a^{n/2} + 1 \equiv 2 \pmod{4}$

буюу $4 \nmid \Phi_n(a)$ болов. $4 \nmid n$ бол $\frac{n}{2} = k$, $a^2 = A$ гэе.

$a^n - 1 = A^k - 1 = (A - 1)(A^{k-1} + \dots + 1)$. II хаалт сондгой ширхэг тоонуудын нийлбэр тул 2-т хуваагдахгүй. Иймд $4 \nmid \Phi_n(a)$.

ДБ-А3: Хариу: $n = 1, 2$.

Өгүүлбэр: $A \subseteq \mathbb{N}$, $|A| = \infty$,

$n = \deg f(x) > \deg(g(x)) = k$, $f(x), g(x) \in \mathbb{Z}[x]$ ба дурын

$a \in A$ хувьд $f(a) \nmid g(a)$ бол $g(x) \equiv 0$ байна.

◀ $f(x) = a_0 + a_1x + a_2x^2 + \dots + a_nx^n$

$g(x) = b_0 + b_1x + b_2x^2 + \dots + b_kx^k \neq 0$ ба

a_n, b_k нь эерэг гэж үзэж болно. $f(x) - g(x) = a_nx^n + \dots$ болох ба $\lim_{x \rightarrow +\infty} (f(x) - g(x)) = +\infty$ тул хангалттай их $a-$ ийн хувьд

$f(a) > g(a) > 0$, $f(a) \nmid g(a)$ гэж зөрчилд хүрэх тул $g(x) \equiv 0$ байна. ▶

$f(x) = x^n + x^{n-1} + \dots + x + 1$; $T(x) = x^{n!} + x^{(n-1)!} + \dots + x^{1!} + 1$ ба

$T(x) = (x^{n+1} - 1) \cdot Q(x) + g(x)$; $Q(x), g(x) \in \mathbb{Z}[x]$ байг.

$x^{n+1} \equiv 1 \pmod{x^{n+1} - 1}$, $+1 \leq k$ үед $k! \equiv \alpha_k \pmod{n+1}$,

$0 \leq \alpha_k \leq n$, гэвэл $x^{k!} \equiv x^{\alpha_k} \pmod{x^{n+1} - 1}$ байна.

$g(x) = x^{\alpha_n} + x^{\alpha_{n-1}} + \dots + x^{\alpha_1} + 1$ болно. $\forall a \in A$ хувьд

$$f(a) \mid T(a) \Leftrightarrow f(a) \mid g(a) \quad (1)$$

байх тул хэрэв $\deg(g(x)) < n$ бол Θ гүүлбэр ёсоор $g(x) \equiv 0$ байна.

Гэвч $\alpha_1 = 1$ тул $\deg(g(x)) \geq 1$ болж зөрчилд хүрнэ. Иймд

$\deg(g(x)) = n$ ба $g(x) -$ ийн сул гишүүн c бол $c \mid f(x) - g(x) = x \cdot g_1(x)$

гэвэл (1)-ээс $\forall a \in A$ хувьд $f(a) \mid g_1(a)$, $\deg f(x) > \deg(g_1(x))$ тул Θ гүүлбэр ёсоор

$g_1(x) \equiv 0$, $cf(x) = g(x)$ болох тул

$$\{\alpha_1, \alpha_2, \dots, \alpha_n\} = \{1, 2, \dots, n\} \quad (2)$$

байна.

$n = 1$ үед $a^1 + 1 \mid a^{1!} + 1$; $n = 2$ үед $a^2 + a + 1 \mid a^{2!} + a^{1!} + 1$;

$n \geq 3$ үед $n + 1 = p \in P$ байг. Вильсоны теоремоор

$(p-1)! \equiv -1 \pmod{p} \Rightarrow (p-2)!(p-1) \equiv p(p-2)! - (p-2)!$

$\equiv -(p-2)! \equiv -1 \pmod{p}$, $(p-2)! \equiv 1 \pmod{p}$ тул $\{\alpha_{p-2}, \alpha_1\} = \{1\}$;

$\{\alpha_1, \alpha_2, \dots, \alpha_n\} \neq \{1, 2, \dots, n\}$ болж (2)-д зөрчинө. $n + 1$ зохиомол

бол $n + 1 = q \cdot k$, $2 \leq q \leq k$, $q, k \in \mathbb{N}$ гэвэл $k + 1 \leq n$ ба

$(k+1)! - k! = k! \cdot k$; $n + 1 = q \cdot k$

$\{\alpha_{k+1}, \alpha_k\} = \{r\}$ тул $\{\alpha_1, \alpha_2, \dots, \alpha_n\} \neq \{1, 2, \dots, n\}$ болж мөн (2)-д

зөрчинө.

$$\text{ДБ-В1: } f(m) = \sum_k \binom{n}{k} \binom{n-k}{\left\lfloor \frac{m-k}{2} \right\rfloor} 2^k \text{ ба } F(x) = \sum_m x^m f(m)$$

гээ. Энэ үед

$$\begin{aligned}
 F(x) &= \sum_m x^m \sum_k \binom{n}{k} \binom{n-k}{\left[\frac{m-k}{2}\right]} 2^k \\
 &= \sum_k \binom{n}{k} 2^k \sum_m \binom{n-k}{\left[\frac{m-k}{2}\right]} x^m \\
 &= \sum_k \binom{n}{k} 2^k \cdot x^k \sum_m \binom{n-k}{\left[\frac{m-k}{2}\right]} x^{m-k} \\
 &= \sum_k \binom{n}{k} 2^k \cdot x^k \times \\
 &\quad \times \left(\sum_{m-k=2k_1} \binom{n}{\left[\frac{2k_1}{2}\right]} x^{2k_1} + \sum_{m-k=2k_2+1} \binom{n}{\left[\frac{2k_2+1}{2}\right]} x^{2k_2+1} \right) \\
 &= \sum_k \binom{n}{k} 2^k \cdot x^k ((1+x^2)^n + x(1+x^2)^n) \\
 &= \sum_k \binom{n}{k} 2^k \cdot x^k (1+x)(1+x^2)^{n-k} \\
 &= (1+x) \sum_k \binom{n}{k} (2x)^k \cdot (1+x^2)^{n-k} = (1+x)(2x + (1+x^2))^n \\
 &= (1+x)((1+x)^2)^n = (1+x)^{2n+1}. \text{ Иймд} \\
 f(m) &= \binom{2n+1}{m} \text{ болж батлагдав.}
 \end{aligned}$$

ДБ-В2: $3 \mid 2^n - 1 \Rightarrow 2^n \equiv (-1)^n(3) \Rightarrow (-1)^n \equiv 1(3)$

$\Rightarrow n$ - тэгш. $n = 2^k \cdot s$, $k \in \mathbb{N}$ s - сондгой натурал тоо байг.

$$2^n - 1 = (2^s)^{2^k} - 1 = (2^s - 1)(2^s + 1)((2^s)^2 + 1) \dots ((2^s)^{2^{k-1}} + 1).$$

$3 \mid 2^s + 1$ ба $s \geq 3$ үед $2^s - 1 \equiv -1(4)$ тул $p = 4k + 3 \mid 2^s - 1$ байх

$$\exists p \in \mathbb{P}. p \mid 4m^2 + 1 \Rightarrow (p; 2m) = 1 \text{ ба } (2m)^2 \equiv -1(p)$$

$$((2m)^2)^{\frac{p-1}{2}} \equiv (-1)^{\frac{p-1}{2}}(p) \frac{p-1}{2} = 2k + 1 \text{ тул } (2m)^{p-1} \equiv -1(p) \text{ бо-}$$

лох нь Фермагийн бага теоремд зөрчинө. Иймд

$$s = 1, n = 2^k, \frac{2^n - 1}{3} = \frac{(2-1)(2+1)(2^2+1)\dots(2^{2^k}+1)}{3}$$

$= (2^2 + 1) \dots (2^{2^k} + 1) = F_1 F_2 \dots F_{k-1}$, үүнд $F_n = 2^{2^n} + 1$ Фермагийн n -р тоо. $F_{n+1} - 2 = F_0 F_1 \dots F_n$ ба Фермагийн тоонууд сондгой тул хоорондоо харилцан анхны. $F_n = 2^{2^n} + 1 = 4(2^{2^{n-1}-1})^2 + 1$

$$\text{тул} \left\{ \begin{array}{lll} 4x^2 + 1 & \equiv & 0(F_1) \\ 4x^2 + 1 & \equiv & 0(F_2) \\ \dots & \dots & \dots \\ 4x^2 + 1 & \equiv & 0(F_{k-1}) \end{array} \right. \quad \text{системийн тэгшитгэл бүр шийдтэй}$$

ба $(F_i, F_j) = 1 \quad (i \neq j)$ тул үлдэгдлийн тухай Хятадын теоремоор систем шийдтэй. Хариу: $n = 2^k$; $k \in \mathbb{N}$ гэж гарна.

